МАНАЙ СОНИНЫ I УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,129.352... УСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.01.31. Мягмар. №020 (4634) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




**УЛС ТӨР**

С.ЭРДЭНЭ: МӨНГӨ ТАРААСАН БОЛ НАМЫН ДАРГЫН СУУДАЛД ОЧИХГҮЙ БАЙХ ЁС ЗҮЙ НАДАД БИЙ

II нүүрт

**ОНЦЛОХ ХУУДАС**

УБТЗ-ЫН ТҮҮХЭНД БИЧИГДЭЭГҮЙ ОЛОН ОСОЛ ГАРАВ

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Болор цом ч ичмээр болдог болж дээ

Н.ПУНЦАГБОЛД

Тэртээ 1983 онд анхны “Болор цом” наадам болж, Д.Пүрэвдорж агсан “Хүн төрөлхтөнд хэлэх үг” шүлгээрээ түрүүлж байснаас хойш даруй 34 жилийн нүүрийг үзжээ. Өмнө нь “Болор цом” наадам жинхэнэ шилдэг яруу найрагчдын шилмэл шүлгэн “хүлгүүд”-ийн уралдаан байлаа. Яруу найрагч Д.Цоодол “Нэр нь тодроогүй баатрууд”, Б.Лхагвасүрэн “Шагнал” тэргүүтэй шүлгүүдээрээ “Болор цом” гардаж байхад жинхэнэ яруу найрагт энэ шагналыг өгдөг байж. Харин цаг хугацааны эрхээр хамгийн сайн шүлэг бичсэн найрагчид биш хамгийн их танил талтай, бэл бэнчинтэй, нутаг усандаа татаастай хүнд л “Болор цом” очдог болж. Тэр дундаа сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт “Болор цом” наадмыг зохион байгуулдаг уламжлал тогтоод байна.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

## С.НАСАНБАТ: Хэдий төсөв санхүү бага ч, бүтээн байгуулалтаа үргэлжлүүлнэ

Х.СОЁЛ

*Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбаттай цаг үеийн асуудлаар ярилцлаа.*

**-2017 он гарсаар аймгийн удирдлагууд нэгдсэн сургалтад хамрагдаж сайдуудтай гэрээ байгууллаа. Энэ жилийн үндсэн зорилго зорилт, үйл ажиллагаагаа юунд чиглүүлж байна вэ. Энэ асуултаас ярилцлагаа эхлэх үү?**

-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, Засгийн газрын гишүүд, аймгийн удирдлагууд хэрхэн хамтран ажиллахаа тодорхойлж, харилцан мэдээлэл солилцох уулзалт Улаанбаатар хотод оны эхэнд боллоо. Мөн салбарын сайд бүртэй гэрээ байгууллаа. Үндсэндээ аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 оны үйл ажиллагааны чиглэл, хийх ажлын төлөвлөгөө улам тодорхой болсон.

**Үргэлжлэл нь VI нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

# С.ЭРДЭНЭ АН-ЫГ ӨӨД НЬ ТАТАХ УУ, УРУУ НЬ ЧИРЭХ ҮҮ



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Н.ПУНЦАГБОЛД

Монголын улс төрийн намуудын түүхэнд анх удаа АН даргаа бүх гишүүдийнхээ саналаар тодруулж, сонголоо. АН-ын 85 мянган гишүүн энэхүү сонгуульд оролцож, олонхи нь С.Эрдэнийн төлөө саналаа өгснөөр шинэ дарга тодорлоо. Түүнтэй хамгийн хүчтэй өрсөлдөөнийг Д.Эрдэнэбат үзүүлэх болов уу гэж олон хүн харж байсан ч тийм зүйл болсонгүй.

**Үргэлжлэл нь III нүүрт**




Манай сонины I улирлын нэмэлт захиалга явагдаж байна

захиалгын үнэ 19800

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

## Утаанаас салах шийдэмгий “ÇÀÑÀÃËÀË”

Ю.ХАЛИУН

ҮАБЗ-өөс агаарын бохирдлыг гамшиг болсон гэдгийг нэгэнтээ зарласан. Утаа гэдэг нэрийн дор үе үеийн Засгийн газар олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн ч төдийлөн үр дүнд хүрсэнгүй. Тухайн үед улсын төсөв болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн хүрээнд багагүй хөрөнгө зарцуулжээ. Тухайлбал, Шинэчлэлийн Засгийн газар 32.1 тэрбум төгрөгийг, Шийдлийн Засгийн газар 9.6 тэрбум төгрөг, АНУ-ын Мянганы сорилын сан 200 гаруй тэрбум төгрөг, Японы ЖАЙКА олон улсын байгууллага агаарын чанарыг хэмжих суурин харуулын 11 станц байрлуулж, автобусанд тортогжилтийг шүүх шүүлтүүр суурилуулан ажилласан байна. Гэвч тухайн үед зарим хэсэгт агаарын бохирдол буурсан гэх мэдээ гарч байсан боловч үр дүн муутай төсөл хөтөлбөрүүд өнөөдрийн гамшигт байдалд хүрэхийг зогсоож чадаагүй юм.

Утааны гамшгийн эсрэг эрс шийдэмгий, зоригтой алхам хийх бүхэл бүтэн засаглал хэрэгтэй болсныг хаа хаанаа хүлээн зөвшөөрч байна. Утаагүй болох хамгийн үр дүнтэй арга бол орон сууцжуулах, барилгажуулах асуудал юм гэдгийг ойлгодог ч зоригтой хэрэгжүүлж чадсан Засгийн газар байсангүй. Харин энэ засгийн газар яаралтай зоримог алхмуудыг хийж чадвал “Ард түмний Засгийн газар” гэж үнэлэгдэх болно. Ингэхийн тулд гадаадын банк оруулж ирж банк санхүүгийн байгууллагад томоохон реформ хийх хэрэгтэй. Гадны банкийг оруулж ирснээр Монголд хэрэгжүүлэх томоохон төсөл хөтөлбөрүүд хөдөлнө. Тэр дундаа иргэдийг орон сууцжуулах, барилгын салбарыг өөд нь татах замаар утааны асуудлыг шийдэх боломжтой болно. Ингэхдээ засгийн газрын 8 хувийн орон сууцны хөтөлбөрийг гадны банкны үйл ажиллагаатай нэн тэргүүнд холбож өгөх хэрэгтэй байгаа тухай эдийн засагчид хэлж байна. МАН-ын Засгийн газраас энэ мэт эрс шийдэмгий, зоримог алхмыг ард түмэн хүлээж байгаа. Засгийн газраас хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэдэн барилгын компани барилга бариад, хэдэн айл орон сууцанд ороод байгаа мэтээр төсөөлөх нь эндүүрэл юм. 100 гаруй мянган хүн ажиллаж байгаа энэ салбарыг Утаанаас салах шийдэмгий “Засаглал”-ын эдийн засгийн цогц хөтөлбөр гэж харах шаардлагатай.

Барилгын салбар өнөөдөр 20-хон тэрбум төгрөгөөр амь зогоох байдлаар удаан явбал дампуурах, үндэсний банкуудад хэдэн зуун тэрбум төгрөгийн өрөө төлж чадахгүйд хүрнэ. Улмаар тус салбарын 100 гаруй мянган хүмүүсийн ажлын байр эрсдэлд орно. Барилгын компанийг дагасан тавилгын үйлдвэрлэл, тавилга импортоор оруулж ирж байгаа компаниуд, зураг төсөл хийж байгаа компаниуд , шугам сүлжээ хийж байгаа компаниуд, төрөл бүрийн барилгын материал импортоор оруулж ирж байгаа компаниуд, хөшиг тогтоодог компани, гэр нүүлгэдэг компани цонх угаадаг компани гээд барилга дагасан бүх төрлийн бизнес зогсож, монголын эдийн засаг хямрах биш, яг утаа шигээ гамшгийн байдалд орох нь тодорхой.

Утаатай тэмцэх шат дараалсан арга хэмжээг хараад байхад эцсийн үр дүнд гэр хорооллыг барилгажуулах нь хамгийн оновчтой, зөв гарц. Хөдөөнөөс орж ирж байгаа хүмүүсийг түр хязгаарлах, цахилгаан зуух зэрэг нь байж болох жижиг асуудлууд юм. Гэвч туйлын үнэн бол Улаанбаатарт амьдарч байгаа иргэдийн 60-70 хувь нь гэр хороололд амьдарч байгаа бөгөөд 160-180 мянган яндангаас гарч байгаа утааг ийм аргаар устгах боломжгүй. Эрх баригчид нийгмийн бухимдлыг туйлд нь хүргэхгүйгээр яаралтай арга хэмжээ авах шаардлага тулгараад байна. Тухайлбал, дээр хэлсэнчлэн гадаадын банкийг оруулж ирэн, томоохон төсөл хөтөлбөрүүдийг, тэр дундаа ипотекийн зээлийн хөтөлбөрийг дордомдож эргэлтийг нэмэгдүүлэх хэрэгтэй. 20-хон тэрбум төгрөгөөр энэ салбарыг төсөөлөхгүйгээр дор хаяж 60-80 тэрбум төгрөгийн тэлэлт хийж чадвал салбарын төдийгүй улс орны эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөг үзүүлэх юм. Үүнд эргэлзэх хэрэггүй. Ипотекийн зээлийн төлөлт бол 99 хувийн найдвартай гэдгийг статистик харуулдаг. Энэ зээлийг яаралтай хэвийн байдалд оруулснаар эдийн засаг тогтворжиж, засгийн газар тууштай тогтвортой ажиллах нөхцөл бүрдэнэ гэдгийг ойлгох цаг нэгэнт иржээ. Хэрэв энэ асуудлыг зөнд нь хаях юм бол Засгийн газрын хувь заяа ч гэсэн өөрөө маш хүнд байдалд орно гэдгийг төрийн түшээ, эрхэм гишүүд, засаг төрийн удирдлагууд гүнээ ойлгож шуурхай ажиллаж байгаа гэдэгт итгэж байна.

Утаанаас салах шийдэмгий алхамыг одоогийн Засгийн газар зоригтой шийдэж, яаралтай хэрэгжүүнэ хэмээн сонгогчид бид итгэж, хүлээж байна. Ард иргэдийн итгэл алдарч, нийгмийн бухимдал дээд түвшиндээ хүрсэн үймээн ямар үр дагаварт хүргэдгийг “7 дугаар сарын 1” бидэнд ойлгуулсан. Утааны гамшиг улс орны эдийн засгийн гамшиг болж, олон нийтийн, Засгийн газрын тогтворгүй байдалд бүү хүргээсэй. Агаарын бохирдлын гамшгийн эсрэг зоригтой алхам хийж, гадны банкыг татаж оролцуулан барилгын салбараасаа эхэлж эдийн засаг, эрүүл мэндээ аварч чадвал энэ Засгийн газрыг “Ард түмний Засгийн газар” хэмээн өргөмжлөхөд ч болохгүй гэх зүйлгүй.

| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2440.00 | 2472.00 | ФУНТ | 3018.00 | 3144.00 | АМ.ДОЛЛАР | 2445.00 | 2472.00 | ФУНТ | 3047.00 | 3138.00 |
| ЕВРО | 2585.00 | 2657.00 | РУБЛЬ | 39.00 | 42.00 | ЕВРО | 2595.00 | 2675.00 | РУБЛЬ | 39.69 | 43.19 |
| ИЕН | 21.09 | 21.60 | ЮАНЬ | 355.00 | 359.40 | ИЕН | 21.15 | 21.81 | ЮАНЬ | 355.00 | 361.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Казахстан Улсын төмөр замын дэвшилтэт технологийг судална

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат “Казахстаны төмөр замууд” хувьцаат нийгэмлэгийн ерөнхийлөгч бөгөөд ТУЗ-ийн дарга К.К.Алпысбаевыг өчигдөр хүлээн авч уулзаж, хоёр улсын тээврийн салбарын хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцлоо. Уулзалтын эхэнд сайд Д.Ганбат хоёр улсын тээврийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд Казахстан Улсын төмөр замын тээврийн салбарын хөгжил, Ази-Европ-Ази чиглэлийн дамжин өнгөрөх тээврийн зохион байгуулалт, төмөр замын хилийн боомт дахь шилжүүлэн ачих байгууламжийн үйл ажиллагаа, хил орчмын эдийн засгийн чөлөөт бүсэд тээвэр логистикийн терминал байгуулсан зэргийн талаар туршлага судлан ажиллаж байгаа талаараа танилцуулав. Мөн Монгол Улсын төмөр замын салбарын мэргэжилтнүүдийн мэргэжил дээшлүүлэх, үүн дотроо зүтгүүр, дохиолол холбоо, төмөр замын цахилгаанжуулалтын чиглэлээр орчин үеийн дэвшилтэт техник технологитой танилцах чиглэлээр хамтарч ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. “Казахстаны төмөр замууд” хувьцаат нийгэмлэгийн ерөнхийлөгч К.К.Алпысбаев “Казахстан Улс нь төмөр замын чиглэлээр шинэ дэвшилтэт технологиуд нэвтрүүлж, ачааны вагоны үйлдвэр, төмөр замын бүхий л тоног төхөөрөмж үйлдвэрлэж байна. Нийт 16500 км төмөр замтай бөгөөд зөвхөн төмөр замаас гадна далайн тээврийн чиглэлд анхаарч ажиллаж байна. Тиймээс төмөр зам, далайн тээврийн салбарт Монгол Улсын зам, тээврийн салбартай санхүүгийн таатай нөхцлөөр хамтран ажиллахдаа таатай байх болно” хэмээн уулзалтын үеэр онцоллоо.


MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.


# С.ЭРДЭНЭ: МӨНГӨ ТАРААСАН БОЛ НАМЫН ДАРГЫН СУУДАЛД ОЧИХГҮЙ БАЙХ ЁС ЗҮЙ НАДАД БИЙ

Ж.ОТГОН

АН-ын удирдлагууд болон даргын сонгуульд оролцсон нэр дэвшигчид мэдээлэл хийлээ. Мэдээлэлд намын дарга З.Энхболд, Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр болон намын сонгуулийн хорооны дарга Ж.Оюунбаатар нэр дэвшигч С.Эрдэнэ, Ж.Батзандан нар оролцов. Харин Н.Алтанхуяг, Л.Гантөмөр, Д.Эрдэнэбат нар мэдээлэлд ирсэнгүй. Мэдээллийн эхэнд намын сонгуулийн хорооны дарга Ж.Оюунбаатарын мэдээлснээр Н.Алтанхуяг 2033.08, Ж.Батзандан 1110.77, Л.Гантөмөр 1417.83, С.Эрдэнэ 2928.92, Д.Эрдэнэбат 857.22 оноо авсан байна. Тиймээс ч АН-ын удирдлагууд албан ёсоор С.Эрдэнийг намын даргаар томилогдож байгааг мэдэгдлээ. Энэ үер АН-ын дарга З.Энхболд “Бид Монголын улс төрийн намын түүхэнд анх удаа энэ ажлыг хийлээ. Одоо намын даргыг гишүүд нь шийддэг болсон. Хуучин системээр сонгогдсон сүүлчийн дарга би байна. Өнөөдрөөс эхлээд нийт гишүүдийнхээ олонхын саналаар сонгогдсон С.Эрдэнэ дарга АН-ын цаашдын реформыг гүнзгийрүүлэн хийж, Монголын улс төрийн голлох намаа ирэх сонгуулиудад ялуулах үүргийг хүлээж байна” гэсэн юм.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Харин ялалт байгуулсан С.Эрдэнэ “Би дөрвөн нэр дэвшигчээ өрсөлдөгч гэж огт хараагүй. Бид цаашид намын шинэчлэлийнхээ төлөө хамтарч ажиллах болно. Сонгуулийн дараа ялагдлын байдалтай байсан АН маань энэ сонгуулиар хөл дээрээ бослоо. Цаашдаа улс төрийн идэвхтэй үйл ажиллагаанд шилжихэд бэлэн болсон гэж харж байна. Биднийг анх өрсөлдөж эхлэхэд таван тийшээ салаад алга болно гэж их олон хүн харж байсан байх. Бид тав нэг үзүүрт сэтгэлээр намын шинэчлэлийн төлөө зорьж ирлээ.Цаашдаа бид намын шинэчлэлийн төлөө хамтарч ажиллах болно. Миний хувьд намын үзэл баримтлалыг баримталж, үндсэн дүрмийн шинэчлэлийг яаралтай хийх, бүтцийн шинэчлэлийг хийхээс ажлаа эхлүүлнэ” гэв. Тэгвэл нэр дэвшигч УИХ-ын гишүүн Ж.Батзандан “Бид сунгаанд өрсөлдөхөөсөө өмнө хэн нь ч дарга болсон тэр хүнээ дэмжиж ажиллахаа илэрхийлсэн. Тиймээс С.Эрдэнэ даргадаа баяр хүргэе. Таны ялалтыг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлье” хэмээсэн юм.

*Мэдээллийн дараа зарим асуултад хариулт авлаа.*

**-З.Энхболд даргыг Ерөнхийлөгчийн сонгуульд оролцохоор тохироо хийсэн гэх мэдээлэл байна. Тиймээс ч С.Эрдэнэ гишүүнийг намын дарга болголоо гэх юм?**

**З.Энхболд:** -Би Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихгүйгээ илэрхийлсэн. 2020 он хүртэл ажил төрөлд очихгүй. Намын хүнд ажлаас холдож амармаар байна.

**-Сонгуулийн үеэр АН-ын зарим гишүүд саналаа өгч чадахгүй байна гэсэн мэдээлэл их цацагдсан. Уг асуудалд тайлбар хийгээч?**

**З.Энхболд:** -Бүртгэлийн тухайд анхан, дунд шатны намууд хувьчлагдчихаад байна гэсэн юм. Анхан, дунд шатны намын байгууллагад бүртгэхгүй байвал төв нам дээр ирж бүртгүүлнэ гэдэг эрхийг нээсэн. Намайг Энэтхэг яваад ирэхэд, Хэрэг эрхлэх газар дээр асуудал үүсгэсэн байсан. Хэрэг эрхлэх газрын ажилтнууд 100, 100-гаар нь хэн нь мэдэгдэхгүй бүртгэл хийсэн байсан. Таван нэр дэвшигчээс Л.Гантөмөрөөс бусад нь тухайн гишүүдийн санал өгөх эрхийг хаах санал гаргасан. Хавар ҮЗХ-ны гишүүдээ шинэчилнэ. Төв нам дээр цугларсан 16 мянган гишүүний бүртгэл саналын эрхтэй болж чадаагүй. Өөрийн биеэр ирээгүй, нэг хүн 100, 100-гаар нь анкет авчирч бүртгүүлсэн. Хэрэг эрхлэх газрын ажилтнуудад хариуцлага тооц гэдгийг Л.Эрхэмбаяр даргад үүрэгдсэн. Өөрийгөө од болсон гэж тооцон анхан шатны нам дээр очиж бүртгүүлээгүй М.Батчимэг гишүүн шиг хүмүүс хохирсон байсан. Баахан алдартай хүмүүсийн зураг хийгээд, тэрний, энэний саналыг З.Энхболд өгүүлсэнгүй гэсэн байсан. Хэн нэг од болсон гишүүдэд гаргах тусгай шийдвэр байхгүй. АН-ын гишүүн бүр адил эрхтэй.

**-Ж.Батзандан гишүүнээс бусад нь таныг хүлээн зөвшөөрөхгүй байгаа гэж ойлгож болох уу. Ерөнхийлөгчийн сонгуульд хэнийг дэмжих вэ?**

**С.Эрдэнэ:** -Бид тавуулаа байнга уулзаж, цуг явсан. Хэн нэг нь ялагч болсон тохиолдолд нөгөө дөрөв нь үг дуугүй хүлээн зөвшөөрч, баг болж явна гэж ярьсан. Манай гурван нэр дэвшигчийн хувьд нойр, хоолгүй явж байсан учраас хүндэтгэх шалтгаан гэж харж байгаа. Биднийг бутарч, хагарчихаасай гэж хүсч байсан бүлэглэл, хүмүүс байсан. Үүнийг давж чадсан. Ерөнхийлөгчийн сонгууль хаяанд байна. Өнөөдөр би хэн нэгнийг нэрлэхгүй. АН-ын дарга болсон ч Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг би тодруулахгүй. Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг саяынх шиг сунгаагаар тодруулах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа. Энэ асуудлыг хоёрдугаар сарын 12-нд болох намын VII их хурлаар тавина.

**-АН фракцгүй нам болно гэж их ярьсан. Та “Шонхор” фракцын хүн шүү дээ. Одоо фракцуудтай хэрхэн ажиллах вэ?**

**С.Эрдэнэ:** -АН-ын даргын сунгаагаар нам өөрөө фракцгүй байх шинэчлэл хийгдсэн. Ямар нэг фракц бүлэглэлийн нөлөөнд орох эрх байхгүй. Би нийт гишүүдийн эрх ашгийг төлөөлж ажиллана.

**-Та Ерөнхий нарийн бичгийн даргаараа хэнийг томилох вэ. Энэ удаагийн мэдээллээс харж байхад Ж.Батзандан гишүүн АН-ын бүлгийн дарга болох юм шиг байна?**

**С.Эрдэнэ:** -Сонгуулийн дүн дөнгөж гарч байна. Тиймээс томилгоог яаран сандрах ярих нь тохиромжгүй.

**Ж.Батзандан:** -Хэн нь ялсан хамтдаа ардчиллын төлөө яваарай гэж бүх гишүүд захиж байсан. Энэ утгаараа өнөөдрийн хуралд ялагчаа хүлээн зөвшөөрч, хамтарч ажиллахаа илэрхийлэхээр ирсэн. Түүнээс биш албан тушаалын төлөө энд ирээгүй.

**-АН-ын даргын сонгуулийн өдөр С.Эрдэнэ гишүүнийг мөнгө тараасан бичлэгийг цацсан. Та үүнд тайлбар өгөөч?**

**С.Эрдэнэ:** - Мөнгө тараасан үйлдэл байхгүй. Хэрэв тараасан бол намын даргын суудалд очихгүй байх ёс зүй надад бий. Одоо хэн дуртай нь нэр нүүрээ нуугаад бичлэг хийгээд бусдыг гүтгэх боломжтой болчихсон. Тэр бичлэг дээр Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн байсан эмэгтэй гол дүрд нь тоглож, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл зохион байгуулсан гэсэн мэдээлэл байсан.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## АН-ын Их хурал хоёрдугаар сарын 12-нд болно

Ардчилсан намын VII Их хурал хоёрдугаар сарын 12-нд болно. Энэ хуралдаанаар шинээр сонгогдсон намын дарга С.Эрдэнийг батламжилж, намын дүрмийн шинэчлэлийг хэлэлцэх юм. Тус намын VI их хурлаар намын даргыг сунгаагаар сонгохоор болж, таван нэр дэвшигч өрсөлдсөн билээ. Намын даргад хамгийн олон санал авсанаар УИХ дахь АН-ын дарга С.Эрдэнэ сонгогдож байна. Мөн VII их хурлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг тодруулах, намын үндсэн дүрэмд өөрчлөлт оруулна. Намын үндсэн дүрмийн шинэчлэлээр намын дарга болон намын удирдлагууд намаа сонгуульд ялагдуулбал огцордог, аймаг, дүүргийн намын хорооны дарга нар УИХ-ын сонгуульд нэр дэвшихгүй байх зэрэг өөрчлөлтүүдийг оруулахаар бэлтгэж байгаа юм байна.

ШАР МЭДЭЭ





## Энхболд нар С.Эрдэнэд “хайр зарлав”

Ж.ӨӨДЛӨН

УИХ-ын гишүүн С.Эрдэнийг АН-ын даргын сонгуульд ялалт байгуулсанд учиргүй ихээр баярлаж байгаа олон хүн байгаа сурагтай. Тухайлбал, сонгууль болсон шөнө буюу өнгөрсөн ням гарагийн шөнө 04:00 цагийн үед С.Эрдэнэ урьдчилсан байдлаар ялалт байгуулсан гэх мэдээлэл хийх үеэр тус намын дарга З.Энхболд хүндэтгэлийг бэлгэддэг лили цэцгийн томоос том баглааг бариад гүйгээд ирсэн гэнэ. МАН-ынхан АН-ын даргын сонгуульд хутгалдсан гэх шуугиан намжаагүй байхад өчигдөр МАН-ын дарга М.Энхболд АН-ын даргын сунгаанд ялалт байгуулсан С.Эрдэнийг хүлээн авч уулзаж, алд цэнхэр хадаг, мөнгөн аягатай сүү барин “хайр зарлаад” амжив. Энэ үеэр С.Эрдэнэ ч М.Энхболдод хариу “сэтгэлээ илчилсэн” гэнэ. Тэрбээр “Эрхэм УИХ-ын дарга Танд баярлалаа. Энэ үйл явдлыг Монголын төрт ёсны соёлын нэгэн илэрхийлэл гэж хүлээж авч байна. АН, МАН бол Монгол төрийн хоёр багана. Энэ хоёр багана гулзайхгүй, бат бөх, тэгш байх ёстой. Намуудын хооронд улс төрийн өрсөлдөөн байх нь дамжиггүй. Гэхдээ бид зөвшилцөл, эв эеийг эрхэм болгож, улс орноо хөгжүүлэх үйл хэргийг туйлын зорилго болгох болно” гэжээ. АН-ын дарга З.Энхболдын хувьд тэрбээр Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох тохироо хийж С.Эрдэнэ гишүүнийг намын дарга болголоо гэсэн яриа гараад байгаа. Харин М.Энхболд юуны учир С.Эрдэнэд “хайр зарлах” болсон нь тодорхойгүй байна.

## БОАЖ-ын сайд Д.Оюунхорол Хөвсгөл аймагт ажиллалаа

БОАЖ-ын сайд Д.Оюунхорол энэ сарын 27-29-ний өдрүүдэд Хөвсгөл аймагт ажиллав. БОАЖ-ын сайдын хамт тус яамны газар, хэлтсийн дарга нар, зарим ТББ-ынхан болон АНУ-ын Дотоод хэргийн яамны харьяа Үндэсний паркийн захиргааны газрын дарга Том Медема, тус паркийн зөвлөх Роберт Макитош нар ажиллалаа. Энэ үеэр Хөвсгөл нуурын бүс нутагт тулгарч байгаа асуудал сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, ТХГН, УЦУОШГ-ын үйл ажиллагааны талаар илтгэл тавьж, АНУ-ын Үндэсний паркийн төлөөлөгчид арга, туршилгаасаа хуваалцаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо. Мөн Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны иргэдтэй уулзаж, орон нутгийн хөгжил, байгаль хамгаалал, аялал жуучлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого, үйл ажиллагааг танилцуулж ард иргэдийн санал хүсэлтийг сонслоо. Уулзалтыг нээж, БОАЖ-ын сайд Д.Оюунхорол хэлсэн үгэндээ “Хөвсгөл нуур болон түүний орчим газар нутгийн байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалж зөв зохистой ашиглан орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд төр засгийн болон орон нутгийнхан та бүхний хамтын ажиллагаа чухал юм. Монголын Швейцарь хэмээн нэрлэгддэг Хөвсгөл нуурын хосгүй үзэсгэлэнт байгаль, орон нутгийн иргэдийн давтагдашгүй нүүдлийн соёл, зан заншил нь гадаад, дотоодын жуулчдын сонирхлыг улам ихээр татаж байдаг. Хөвсгөл нуурын БЦГ-ын аялал жуучлалын бүсэд өнөөдрийн байдлаар 118 иргэн, аж ахуйн нэгж байгууллага нийт 561.74 га газарт аялал жуучлалын үйл ажиллагаа явуулах, газар ашиглах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авснаас 38 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага аялал жуучлалын үйл ажиллагаа эрхэлж, жилд долоон сая гаруй төгрөгийн орлогыг орон нутагт оруулж байна. Монгол Улсын аялал жуучлалын гол төв болсон аймгийн хувьд жуулчдыг хүлээн авах даац нөөцийг зөв тогтоож, цаашид хэрхэн хангах, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, биологийн олон янз байдлыг хамгаалах зэрэг асуудлыг анхаарж ажиллах шаардлагатай байна. Орон нутгаас тодорхой ажлуудыг хийж байгаа ч төсвийн хүрэлцээ, санхүүжилт хөрөнгө мөнгө дутмаг байгааг орон нутгийн удирдлагууд хэлж байна. Тиймээс энэ асуудлыг зөвхөн төсвийн хөрөнгө харахгүй орон нутагт хэрэгжиж байгаа олон улсын төсөл хөтөлбөрийн тусламжтайгаар шийдвэрлэхээр ажиллаж байгаа” гэлээ. Хатгал тосгоны иргэд албаны хүмүүст хэд хэдэн санал уламжлав. Үүнд Хатгалын тосгоны статусыг дээшлүүлэх, хог хаягдал, аялал жуулчлалын үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлэх, байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийг нэмэгдүүлэх асуудлуудыг тавилаа. Мөн аялал жуулчлалыг түшиглэсэн нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аялал жуулчлалын мэдээллийн төв, цогцолбор байгуулах шаардлагатай байна гэв. Ард иргэдийн санал бодлын үндсэн дээр боломжтой зарим асуудлыг шийдвэрлэхээр боллоо. Юуны өмнө Хатгал тосгоны статусыг сумын статустай болгох асудулыг Засгийн газраар хэлэлцүүлэхээр болов. Мөн Хатгал тосгоны соёлын төвийг сургалт сурталчилгаа, соёлын үйл ажиллагааны төв болгоход дэмжлэг үзүүлж, засварын ажилд 10 сая төгрөгийг шийдвэрлэж өгөхөөр боллоо. Мөн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг нуур орчмын эко системийг судлах судалгааны ажилд тодорхой хөрөнгийг төсөвт суулган шийдвэрлүүлэхээр болов. “Монголын экологийн төв” ТББ-аас дэмжлэг үзүүлж Хатгал сумын ЕБС-ын сурагчдын дунд хэрэгжүүлж байгаа “Өсвөрийн байгаль хамгаалагч” хөтөлбөрийн үйл ажиллагаатай БОАЖ-ын сайд мөн танилцлаа. Өсвөрийн байгаль хамгаалагчдын үйл ажиллагааг дэмжиж БОАЖ-ын сайд Д.Оюунхорол гарын бэлэг гардуулж, хувиасаа гурван сая төгрөг хандивлалаа.

## УИХ дахь МАН-ын бүлэг мэдээлэл хийсэнгүй

УИХ дахь МАН-ын бүлгийн өчигдрийн хуралдаанаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуулийн төсөл, Төрөөс төмөр замын салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах тухай хуулийн төслийг хэлэлцсэн байна. Түүнчлэн Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тухай хуулийн төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулуулах тухай хуулийн төслийг хэлэлцжээ. Гэхдээ энэ удаад бүлгийн хурлын тадаар мэдээлэл хийхгүй гэв.

## ҮЗЭЛ БОДОЛ

# С.ЭРДЭНЭ АН-ЫГ ӨӨД НЬ ТАТАХ УУ, УРУУ НЬ ЧИРЭХ ҮҮ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Санал авсан үзүүлэлтээрээ Н.Алтанхуяг хоёр, Л.Гантөмөр гурав, Ж.Батзандан дөрөвдүгээрт жагссан юм. Мэдээж сонгууль болгоны дараа янз бүрийн л асуудал үүсч, хэл ам дагуулдаг. Ялагдлаа хүлээн зөвшөөрөхгүй байх, янз бүрийн бичиг сачиг шидэлцэх нь гэм биш зан. Түүнийг нь АН-ын даргын сонгууль тойрсонгүй. Сонгуулийн дүн нэгэнт тодорхой болж, С.Эрдэнэ ялсны дараа зарим нэр дэвшигчид эсэргүүцнэ энэ тэр гээдл гүйлдсэн. Тэр нь сүүлдээ тохироо хийснээр өндөрлөв бололтой, өчигдөр тэр талаар л баахан таамаг явлаа. За тэр ч яахав, нэгэнт асуудал шийдэгдсэн. С.Эрдэнэ намын дарга боллоо. Одоо АН яах вэ гэдэг л байна.

### АН–ыг зангидаж чадах жинхэнэ менежер

Мэдээж аливаа зүйлд хоёр тал бий. Хүнд ч гэсэн сайн, муу хоёр тал бий шүү дээ. Тэгвэл сайнаас нь эхэлье. С.Эрдэнэ гишүүн бол сайн менежер юм гэдэг нь сүүлийн хэдэн жил Баянголоос дараалан сонгогдож байгаагаас харагдана. Дээрээс нь Баянгол дахь нөлөөллөө нэмэгдүүлж чадсан, тэнд байр сууриа нэгэнт олсон хүн. Хүмүүс Баянгол дүүрэг С.Эрдэнийнх боллоо, Эрдэнэ Вантан энэ тэр гээд л муугаар хэлээд байдаг. Гэтэл түүн шиг тойргоо тойглож, сонгогчдынхоо итгэлийг олж авсан хүн АН-д байгаа бил үү. Сая 2016 оны сонгуулиар найдвартай гарна, дархлагдсан гэж байсан хүмүүс унасан. Хөдөөгийн тойргуудад АН-аас найдвартай сонгогдох хүн цөөнгүй байгаа гэгдэж байсан. Гэтэл яав, өвдөг шороодоо биз дээ. Улаанбаатар хотод ч гэсэн тэр дүүргээс энэ хүн гарна гэж байсан ч чадаагүй. Харин С.Эрдэнэ гишүүн Баянголоос найдвартай гарсан. Тэр ч битгий хэл орон нутгийн сонгуулиар Баянголд Ардчилсан нам үнэмлэхүй ялалт байгууллаа. Хэрвээ Баянголд АН ялбал УИХ-ын гишүүн асан С.Одонтуяаг дүүргийн Засаг даргаар томилно гэсэн шийдвэр гаргасан менежент нь сонгуульд ялахад багагүй хөшүүрэг болсон ч гэж дүгнэж болохоор. Ийм менежменттэй хүн АН-д түүнийгээ хэрэглээд, зохицуулаад, өөд нь татах боломж байгаа. Тэгээд ч С.Эрдэнэ бол шат шатанд ажиллаж, хэдэнтэй гишүүнээр сонгогдож, салбарын сайд хийж явсан хүн. Намба, зангараг, чадвар, менежмент гээд бүхий л чадвар энэ хүнд байна. Фракцийн хагарлаасаа болоод замаа алдчихсан, сөнөх дээрээ тулчихаад байгаа АН-ыг аврах арга тэр хүний толгойд байгаа нь тодорхой. Нөгөө талаар С.Эрдэнийг АН-ынхны ихэнх нь дэмжиж байгаа юм билээ. Тийм болохоор урагшаа ахих боломж байгаа. Энэ онд Ерөнхийлөгчийн сонгууль болно. Тэр сонгуулиас эхлээд л С.Эрдэнэ даргын ямархуу менежменттэй, зөв пиартай оролцож чадах нь харагдах учиртай. Нөгөө талаар АН нэгэнт намын даргаа бүх гишүүдийнхээ саналаар сонгохоор болоод, шийдээд, тэр ажлынхаа ард гарчихлаа. Таван хүн өрсөлдсөний нэг нь сонгогдлоо. Одоо олон таван үг яриад, элдэв хоёр болоод байх шаардлага байхгүй. Тэртээ тэргүй Монголын улс төрд байгаа хоёр том хүчний нэг нь. Энэ нам ямархуу хэмжээнд ажиллаж, бодлого зорилгоо тодорхойлж, зөв замаар явж гэмээнэ Монгол Улсад л хэрэгтэй. Тийм болохоор ялсан, ялагдсан гээд ялархаад, гомдоод суулгүй нэгдэж ажиллах цаг болсон. Хэрэв тэгж чадахгүй бол Ерөнхийлөгчийн сонгууль, цаашлаад 2020 оны УИХ-ын сонгуулиар АН хөөрхий болно. Гишүүд нь дахиад дөрвөн жил “лааз өшиглөх” болох байх. Ингээд л улс төрийн тоглоомноос хэсэгтээ арчигдах гээд байна. Тийм болохоор нэгэнт сонгогдсон даргынхаа мэдлэг, чадвар, менежментэд найдаад, хамтраад, нэг зүг хараад зүтгэх хэрэгтэй. С.Эрдэнэ гишүүн Баянголын АН-ыг зангидаж чадсан хүн тэр зарчмаараа нийт намаа нэгтгэж, өөд нь татаж чадах нь гарцаагүй.

### АН хагарч, бутрахад амархан байна

Одоо нөгөө талаас нь хараад үзье. С.Эрдэнэ гишүүнд нэг сул тал бий. Тэр нь намын жирийн гишүүд дэмжигчдийн дунд жаахан нэр хүнд муутай гэгддэг. Дээрээс нь түүнтэй холбоотой элдэв шалдав яриа, хар пиар дагуулдаг хэл амыг ярьвал бөөн л юм бий. Ер нь бол сая мань хүн мөнгө тараасан, өөрсдийнхөө дэмжигчдийг намын шинэчилсэн бүртгэлд илүүтэй бүртгүүлсэн гэх мэт хэл аманд ч орооцолдоод байгаа юм. Яахав, өөрөө бол тэр болгоныг үгүйсгэсэн. Түүний эсрэг зохион байгуулалттай явуулга ч гэж хэлнэ билээ. Магадгүй тийм ч байх, үгүй ч биз. Дээрээс нь түүнийг намын даргын сонгуульд ялалт байгууллаа гэдэг нь тодорхой болоход өмнөх дарга З.Энхболд цэцэг барьж гүйж очсон. Өчигдөр МАН-ын дарга М.Энхболд хадаг, мөнгөн аягатай барьж, сүрхий хүндлэл үзүүлсэн нь ч гэсэн элдэв яриан дээр тос асгачихаад байна. Тийм болохоор АН эвлэрэх биш харин ч бутарч магадгүй байдал руу оруулж байгаа юм. Ер нь бол АН 4-5 цуурсан “шаазан” байсан шүү дээ. Тэгвэл одоо тэр олон цууралтын нэг хэсгээр нь хагарчихаж магадгүй юм. Зарим хүмүүс АН-ын зарим гишүүд намаасаа гарч, шинэ нам байгуулж магадгүй нь. Эсвэл өөр намд ч орж болох. Ингээд Ерөнхийлөгчийн сонгуулиар хэд хэдэн хүн үзэх магадлал өндөр болчихлоо гэж дүгнээд байна. Нэг талдаа үүнийг үгүйсгэх арга байхгүй. Цаагуураа С.Эрдэнэ намын дарга болохыг хүлээн зөвшөөрч, сэм тохирч, нам хуйвалдсан байж болно. Гэтэл наагуур нь бас намаасаа гараад явчих, уур ундуйцал нь хүрчихсэн хүмүүс байгаа. Ер нь л бутарчихаж магадгүй шүү дээ. Тийм болохоор цуурчихсан намаа жаахан болгоомжтой авч явж, алдаад хагалчихгүйн төлөө л ажиллах шаардлага шинэ даргад тулгараад байна. Ер нь жаахан бөөцийлөл, зөв менежмент л хэрэгтэй байна даа. Ямар ч байсан эхний ээлжинд Ж.Батзандан гишүүнийг УИХ дахь АН-ын бүлгийн даргаар тавихаар тохирсон гэсэн явган яриа гарч эхэллээ. Яахав дээ, тавьж л байг. Одоо Л.Гантөмөрийг генсекээр тавиад, Н.Алтанхуягийг Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдүүлчих хэрэгтэй байгаа юм. Д.Эрдэнэбат гишүүн яах вэ, тэртээ тэргүй хоёрын хооронд юм яриад, гон гон хийгээд явахгүй хүн. Гэхдээ тэр хүний нэр хүнд, ноён нурууг бас ашиглах л хэрэгтэй. Ер нь АН-д хэрэггүй хүн байхгүй, бүгд л эвлэлдэн нэгдэж, хамтран ажиллаж, нийтээрээ л урагшлах ёстой. Тэр замыг нь дарга нь засч, чиглүүлэх л хэрэгтэй байна. Тэгэхгүй бол АН гэдэг “шаазан” бут үсэрчих вий дээ.

> ...Фракцийн хагарлаасаа болоод замаа алдчихсан, сөнөх дээрээ тулчихаад байгаа АН-ыг аврах арга тэр хүний толгойд байгаа нь тодорхой. Нөгөө талаар С.Эрдэнийг АН-ынхны ихэнх нь дэмжиж байгаа юм билээ. Тийм болохоор урагшаа ахих боломж байгаа. Энэ онд Ерөнхийлөгчийн сонгууль болно...

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын 60 мөр

## Болор цом ч ичмээр болдог болж дээ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Бодвол Монголын зохиолчдын эвлэлийнхэн аль нэг аймгийн Засаг даргын тамгын газраас ихэнх хөрөнгө мөнгийг нь гаргуулаад, “Болор цом” зохион байгуулчихдаг болохоор амтанд нь орчихоод байгаа юм биш үү. Тэгээд л хөдөө руу зулраад, тэр нутгийнх нь нэг нөхөр юу ч хамаагүй уншаад л түрүүлдэг “наймаатай” болчихлоо. Ёстой “Болор цом” гэдэг чинь хамгийн их ичиж, бөгс улаймаар наадам болж дээ. Энэ жил гэхэд “Болор цом” Сүхбаатар аймагт болж, Б.Батсайхан гэдэг яруу найрагч түрүүллээ. “Болор цом”-ын эзэн А.Эрдэнэ-Очир аман хүзүүдэж, Ч.Ууганбаяр, Д.Гансүрэн, М.Уянсүх нар удаалсан юм. Б.Батсайхан гэдэг нь Сүхбаатар аймгийн харьяат яруу найрагч юм гэнэ билээ. Ард түмэнд тэгтлээ танигдаагүй, “битүү морь” юмдаг уу даа. Тэгээд дээрээс нь жаахан бэлдмэл энэ тэр хийж уралдсан “морь” бололтой юм. Сүхбаатар аймгийн Засаг даргын эхнэрийнх нь садан ч гэнэ үү нэг балай юм дуулдсан. Түүнийхээ хүчээр, дээрээс нь Сүхбаатар аймгийнх учраас ийн “магнайдаа тоосгүй” ирсэн ч гэж яриад байна. За тэр шүлэг энэ тэрийг нь мэргэжлийн шүүмжлэгчид нь шүүмжилж, хэлэх юмаа хэлэх байлгүй дээ. Сошиалаар бол муугаар нь дуудаад л байна. “Хүрэл тулга” наадамд оролцож байгаа хүүхдүүд ч үүнээс дээр шүлэг уншина гээд л байх юм. Зарим нь ч бүр дөрөвдүгээр ангид байхдаа ч түүнээс илүү шүлэг бичдэг байсан тухайгаа дурссан байна билээ. Өөр бусад нь болохоор “усан шүлэг” гэдэг тодотгол зүүсэн харагдсан. Олны үг ортой гэдэг дээ. Тэгээд шүлэг, яруу найрагт ойрхон хүмүүс бол бас ч гэж ханатай л дүгнэж байгаа байх. За тэр ч яахав, хамгийн гол нь “Болор цом” наадмаа ингэж завхруулахаа болих цаг болсон юм биш үү. Ийм ичмээр юм хийчихээд, дараа нь хүний царай яаж харж чаддаг байна аа, энэ Зохиолчдын эвлэлийнхэн. Хэзээ ч билээ Ж.Мөнхбат гээд нэг намын нөхөр “Болор цом” хүртээгүй юу. Тэр үеэс л хэл ам гарсан шүү дээ. Таван саяар тэр цомыг нь худалдаж авсан энэ тэр гээд л. Түүнээс хойш Дарханд Ц.Хулан, Архангайд Д.Болдхуяг, Өвөрхангайд Л.Моломжамц гээд л ээлж дараалан түрүүлсэн. Тэр нутгийнх байсныхаа төлөө түрүүлэх эрхээр шагнуулсан гээд байгаа. Бас төв аймагт болоход нэг нөхөр түрүүлсэн дээ. Бас л нутгийнх гэдэг шалтгаанаар түрүүлэх эрх олж авсан гэсэн элдэв яриа бий. Яахав, заримынх нь эцсийн шатанд уншсан шүлэг гологдоод байхааргүй л байсан болов уу. Заримынх нь ч гологдож л байсан байх. Гэхдэ энэ жилийнх шиг муугаараа дуудуулж байгаагүй юм байна. Дараа жилүүдээс үлдсэн бүх аймагтаа зохион байгуулаад, тэр нутгийнх нь л бол нэг хүнийг түрүүлүүлэх байх л даа. Харин тэр хүнийх нь шүлэг “Хүрэл тулга”-ын нэгийн даваанд тэнцчихээр гэсэн үнэлгээ аваасай билээ дээ, өөр ч юу гэхэв. Жил ирэх тусам л “Болор цом” ичмээр болж, зохион байгуулагчдынх нь ичих булчирхай жижгэрсээр л байх юм даа.

# ДЭЛХИЙ

## АН САН СУ ЧИГИЙН НАМЫН ХУУЛИЙН ЗӨВЛӨХ АМИА АЛДЛАА



Б.ДАВААХҮҮ

Мьянмарын хамгийн том хот болох Янгоны нисэх онгоцны буудалд ардчиллын төлөө тэмцэгч Ан Сан Су Чигийн тэргүүлэх эрх баригч "Ардчилсан холбоо" намын хуулийн зөвлөх нарын хоёр томоохон албан тушаалтан үл таних этгээдэд буудуулж, амиа алджээ. Улмаар нисэх буудлын аюулгүй албаныхан шуурхай ажилласны дүнд гэмт этгээдийг хэргийн газарт баривчилж, ямар учраас хүний аминд хүрэх болсныг нь шалгах ажиллагааг эхлүүлсэн байна. Хэрэг Янгоны нисэх онгоцны буудлын олон улсын терминалын таксины зогсоолын ойролцоо гарчээ. Цагдаагийн газраас мэдээлж буйгаар хэргийн улмаас хоёр хүн нас барсны нэг нь Ан Сан Су Чигийн намын хуулийн зөвлөх Ко Ни байсан бол нөгөө нь таксины жолооч байжээ. Хэргийг 50 гаруй насны эрэгтэй хүн үйлдсэн байна.

Ко Ни Су Чид олон жилийн турш хуулийн туслалцаа үзүүлж ирснээс гадна Ардчилсан хөдөлгөөн намд байдаг хэдхэн мусальман шашинт албан тушаалтны нэг гэдгээрээ танигддаг байв. Одоогоор албаныхан хэргийг зохион байгуулалттай гэмт хэрэг гэж үзэж байгаа аж. Гэхдээ ямар шалтгаанаар хөнөөсөн нь тодорхойгүй байна. Хэрэг гарах үед Ко Ни ач хүүгээ тэвэрсэн байжээ. Энэ талаар түүний охин Ен Нве Хин "Аав минь ачтайгаа яриад явж байсан юм. Гэтэл гэнэт л буун дуу сонсогдсон. Эхэндээ би машины дугуй хагарч байгаа юм болов уу гэж бодсон. Гэтэл аав газарт унасан байсан" гэж ярьжээ. Түүнчлэн Ко Ни амьд сэрүүн байхдаа Мьянмарт цэргийнхний хүч нөлөө хадгалагдсаар байгааг удаа дараа эрс шийдэмгийгээр шүүмжилж ирсэн нь олон дайсантай болгож байсан гэнэ. Охин нь ярихдаа "Эцэг минь байнга л сүрдүүлэгт өртдөг байсан. Бид нар тухай бүрт болгоомжтой байхыг сануулдаг байсан ч, аав амаа хамхихыг хүлээн зөвшөөрдөггүй. Тэр үргэлж зөв гэж бодсон зүйлээ л хийдэг байлаа. Бид өөр шашны итгэл үнэмшилтэй учраас олон хүн биднийг үзэн яддаг. Яагаад түүнд ийм зүйл тохиолдсон шалтгааны би үнэндээ хэлж мэдэхгүй байна" гэж өгүүлжээ. Харин таксины жолооч буутай этгээдийг зогсоохыг оролдож байхдаа амиа алдсан байна. Энэ талаар Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч Зау Хтай "Бид хэрэгтнийг саатуулсан. Улмаар хүний амь бүрэлгэх болсон шалтгаан, түүний ард хэн байгаа, түүнд хэдийг төлсөн гэх мэт асуудлыг тодруулж байна" хэмээн хэвлэлд өгсөн ярилцлагадаа дурьдсан байна. Мьянмарын баруун этгээдийн Ракхайн мужид цөөнхийн лалын шашинтан болон олонхийн буддын шашинтнууд хоорондын сөргөлдөөн үргэлжилж буй бөгөөд цагдаагийнхан ч, энэ удаагийн хэрэг шашны зорилготой байж магадгүй хэмээн таамаглаж байгаа юм байна.

## Лех Валенса тагнуул байсныг батлах шинэ баримт дэлгэнэ

Польшийн ардчилсан хөдөлгөөний удирдагч, Нобелийн энх тайвны шагналт Ерөнхийлөгч Лех Валеса коммунист дэглэмийн үед тагнуул байсан гэдгийг батлах маш нууц баримт материалыг прокурорынхон өнөөдөр олон нийтэд зарлах гэнэ. Тус улсын "PAP" гэх агентлаг Нацист Герман болон коммунист дэглэмийн үед гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий байгууллагатай ойр ажиллаж байсан нэрээ нууцалсан нэгэн эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан дээрх мэдээллийг олон нийтэд цацжээ. Улмаар ардчилсан "Solidarity" хөдөлгөөний удирдагч байсан Валенсаг тагнуул байсныг батлах нотлох шинэ баримтуудыг нийтэд цацахаа мэдэгдсэн байх юм. IPN агентлаг өнгөрсөн жил коммунист дэглэмийн үеийн Дотоод хэргийн сайдын эхнэрээс авсан цагдаагийнхны нууц баримтад "Лех Валенсагийн код нэр болох Болек гэх нэрийг бичсэн хамтран ажиллах гэрээ байсан гэдгийг мэдээлж байсан удаатай. Гэвч тухайн үед 1989 оны цусгүй хөдөлгөөнийг удирдсан экс Ерөнхийлөгч Валенса тус баримтыг удаа дараа үгүйсгэж байжээ. Харин өнөөдөр түүнийг тагнуул гэдгийг батлах нууц баримт бичиг дэлгэгдэх бололтой. Хэрэв энэ материал батлагдвал, Польшийн "Эв санааны нэгдэл" үйлдвэрчний эвлэлийн толгойлогч, тус улсад коммунист дэглэмийг унагасны төлөө Нобелийн энх тайвны шагнал хүртэж байсан Лех Валенса үнэн хэрэгтээ коммунистуудын нууц тагнуул байсан нь илрэх юм. Лех Валеса Гданьск хотын хөлөг онгоцны үйлдвэрийн жирийн ажилчин байхдаа "Болек" хэмээх нууц нэрээр тагнуулын албанд нууц мэдээлэгчээр ажиллаж байжээ.

## Диана гүнжийн хөшөөг босгох гэнэ



Их Британийн хааны ордон зам тээврийн ослоор нас барсан Диана гүнжийн дурсгалд зориулан хөшөө босгохоор болжээ. Диана гүнж цаг бусаар тэнгэрт хальснаас хойш 20 жил болж буй. Тэгвэл энэ өдрөөс урьтаж амьдарч байсан ордных нь хашаанд гүнжийн хөшөөг босгохоор төлөвлөжээ. Энэ санааг Ханхүү Уильям, Харри нар санаачилсан бөгөөд тэд эхийнхээ амьд сэрүүн ахуйдаа амьдарч байсан Кенсингтоны ордны хашаанд хөшөөг бариулах гэнэ. Уильям, Харри нар хөшөөг босгох ажлын хэсгийг байгуулснаас гадна зарцуулагдах хөрөнгө төсвийг хэдийнэ бүрдүүлсэн байна. Одоогоор хөшөөг барих уран баримална сонгох үйл ажиллагаа үргэлжилж буй бөгөөд энэ жилдээ багтаан барьж дуусахаар төлөвлөжээ. Тэд "Ээж нас барснаас хойш 20 жил өнгөрч байна. Тэр эмэгтэйн Их Британи болон дэлхий дахинд үзүүлсэн эерэг нөлөөг баталгаажуулахад яг тохирох үе" гэж тайлбарласан байна. Диана гүнж 1997 оны наймдугаар сард Парис хотод авто ослоор өөд болсон юм.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллагын Хорих 433-р ангийн хэрэгцээнд Галын түлээ, нүүрс нийлүүлэх гүйцэтгэгчийг шалгаруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **Хорих 433-р анги 2017/03 БМ**

**Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хорих 433 дугаар анги**йн нь эрх бүхий тендерт оролцогчдоос Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллагын хэрэгцээнд хорих 433-р ангийн нүүрс, **Галын түлээ, нийлүүлэх гүйцэтгэгчийг шалгаруулах тухай битүүмжилсэн** тендер ирүүлэхийг урьж байна.

| Багцын дугаар | Багцын нэр | Баталгааны дүн /төг/ |
|---|---|---|
| Багц 1 | Нүүрс | 34,00,000 |
| Багц 2 | Галын түлээ | 3000,000 |

Тендерийн бичиг баримтыг (хvсвэл нэмэлт хувийг) бичгээр хvсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгvй нөхцөлтэйгээр иж бvрдэл бvрийг нь **50000 төгрөг,** эсхvл тvvнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Төлбөрийг дансаар Сэлэнгэ, Мандал Төрийн сангийн 100130412004 тоот төгрөгийн дансанд тушаана. Тендер нь тvvнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хvчинтэй байна.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн нэг - хувьтай тэнцэх хэмжээний төгрөг (эсхvл тvvнтэй тэнцэх чөлөөтэй хөрвөх валют)-ийн дvнтэй тендерийн баталгаа ирvvлнэ.

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн аль нэг жилийн борлуулалтын орлого нь тендерт санал болгох үнийн дүнгийн 100%-с багагүй байх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт санал болгох үнийн дүнгийн 30%-с багагүй байх. Хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил 2015, 2016 /аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ/, санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдсэн байх**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил /2015, 2016 / Ижил төстэй ажлын өртөг нь тендерт санал болгох үнийн дүнгийн 50%-с багагүй байх**

Тендерийг **2017 оны 01-р сарын 13- ны өдрийн 12 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирvvлэх ба нээлтэд оролцох хvсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 02-р сарын 24-ний өдрийн 12 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Сэлэнгэ аймгийн Мандал сумын хорих 433 дугаар анги**
**Утас:99164887**

# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллагын хорих 433-р ангий хэрэгцээнд шатахуун нийлүүлэх гүйцэтгэгчийг шалгаруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **Хорих 433-р анги 2017/02 БМ**

**Сэлэнгэ аймгийн Мандал сумын шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллагын Хорих 433-р ангийн хэрэгцээнд шатахуун, нийлүүлэх гүйцэтгэгчийг шалгаруулах тухай битүүмжилсэн** тендер ирүүлэхийг урьж байна.

| Багцын дугаар | Багцын нэр | Баталгааны дүн / төг/ |
|---|---|---|
| Багц 1 | Шатахуун | 42,687,000 |

Тендерийн бичиг баримтыг (хvсвэл нэмэлт хувийг) бичгээр хvсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгvй нөхцөлтэйгээр иж бvрдэл бvрийг нь 50000 төгрөг, эсхvл тvvнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Төлбөрийг дансаар Сэлэнгэ, Мандал Төрийн сангийн 100130412004 тоот төгрөгийн дансанд тушаана. Тендер нь тvvнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хvчинтэй байна.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн нэг - хувьтай тэнцэх хэмжээний төгрөг (эсхvл тvvнтэй тэнцэх чөлөөтэй хөрвөх валют)-ийн дvнтэй тендерийн баталгаа ирvvлнэ.

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн аль нэг жилийн борлуулалтын орлого нь тендерт санал болгох үнийн дүнгийн 100%-с багагүй байх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт санал болгох үнийн дүнгийн 30%-с багагүй байх. Хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил 2015, 2016 /аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ/, санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдсэн байх**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил /2013, 2014/ Ижил төстэй ажлын өртөг нь тендерт санал болгох үнийн дүнгийн 50%-с багагүй байх**

Тендерийг **2017 оны 01-р сарын 13- ны өдрийн 12 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирvvлэх ба нээлтэд оролцох хvсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017оны 02-р сарын 24-ний өдрийн 12 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хорих 433-р анги**
**Утас:99164887**

# ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронд

# УБТЗ-ЫН ТҮҮХЭНД БИЧИГДЭЭГҮЙ ОЛОН ОСОЛ ГАРАВ

УИХ-ын сонгуулиас үүдэлтэй албан байгууллагуудын халаа сэлгээний асуудал Монголын томоохон "мөнгөний машин" гэгддэг УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийг ч тойрсонгүй. Харин энэхүү даргын албан тушаалын төлөөх улс дамнасан хэрүүлийнх нь хохирогчид иргэд болон тус компанийн ажилчид болчихоод байгаа талаар амтай болгон ярьж буй. Бүр тодруулбал, даргын суудлын төлөөх асуудлаас үүдэн анхаарал, хариуцлага суларсан бололтой. Энэ хугацаанд нь төмөр замын ослоор таван хүн амиа алдаж, нэг хүн хүнд бэртсэн харамсалтай хэрэг гарсан. Гэвч УБТЗ-ын удирдлагуудын зүгээс дээрх ослын талаар сэрэмжлүүлэг, мэдээллийг нэг ч хүргээгүй нь олны анхаарлыг татаад буй. Тухайн үед хэвлэл мэдээллийн байгууллагууд ч дэлгэрэнгүй мэдээлэл авах гэсэн боловч албан тушаалтнууд нь өөрсдөөсөө зайлуулж, аргацаасан байдлаар хандаж байсан билээ. Харин нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалжууд УБТЗ-ын түүхэнд ийм ойрхон хугацаанд олон хүн амиа алдсан осол гарч байгаагүй гэдгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлсэн. Тиймээс энэ удаагийн "Онцлох хуудас" булангаараа энэ асуудлыг онцолж байна.

### УБТЗ: ЭНЭ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ

Аравхан хоногийн дотор таван хүний амь нас аюулгүй ажиллагааг хангаагүйн улмаас сүйдсэн байтал энэ талаар арга хэмжээ авч, хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналтаа сайжруулж, иргэдэд сэрэмжлүүлэх нь байтугай энэхүү мэдээллийг УБТЗ-ынхан нууцалсаар байсан юм. Энэ талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах гэсэн боловч албан тушаалтнууд нь өөрсдөөсөө зайлуулж, аргацаасан байдлаар хандаж байв. Тиймээс дээрх мэдээлэл хэр бодитой эсэх талаар УБТЗ-ын Олон нийттэй харилцах 2124109 дугаарын эх сурвалжаас тодруулахад "Энэ талаар мэдээлэл өгөх боломжгүй" гэсэн хариуг өгсөн юм.

### УБТЗ АЖИЛЧНЫХАА ҮХЛИЙГ НУУЦАЛЖЭЭ

**2016.12.29:** Эхний осол он солигдох мөчид Чойрын Шивээ-Овоогийн өртөөнд гарчээ. Тодруулбал, 2016 оны арванхоёрдугаар сарын 29-ний өдрийн 08:45 цагт тус өртөөний галт тэрэгний туслах найруулагч вагонд зүтгүүр залгах үеэрээ дунд нь хавчуулагдаж, амиа алджээ. Ослын талаар урьдчилсан байдлаар дүгнэлт гарсан бөгөөд тухайн үед үүрэг гүйцэтгэж байсан галт тэрэгний удирдагч туслах найруулагчийн ажилд хяналт тавиагүй, сэлгээний хөдөлгөөнийг өөрөө удирдаагүй зэрэг үүргээ биелүүлээгүйн дээр Зам тээврийн сайдын тушаалыг зөрчиж, мэргэжлийн бус хүнийг галт тэрэгний туслах найруулагчийн орон тоон дээр нэг сар дадлагажуулж ажиллаж байсан. Амиа алдсан туслах найруулагч үүргийнхээ заалтыг зөрчин, буруу ажилласан гэж урьдчилсан дүгнэлтэд дурьджээ. Талийгаач 20 гаруйхан настай залуу байсан бөгөөд УБТЗ-д ажилд ороод удаагүй, арванхоёрдугаар сарын 24-нд ажлын байрных нь тушаал гараад байсан аж. Осол болсон өдөр талийгаачийн ажлынх нь гурав дахь гараа байсан гэнэ. Тэрбээр төмөр замын сургууль төгсөөгүй бөгөөд биеийн тамирын багш мэргэжилтэй нэгэн аж. Дашрамд дурьдахад, ийм ноцтой осол гарсан байтал УБТЗ-ын удирдлага сэрэмжлүүлэг, мэдээлэл гаргахын оронд маргааш нь нэгдсэн шинэ жилээ тэмдэглэж байсан гэж байгаа юм.

### УБТЗ-ЫН АЖИЛТАН ГАЛТ ТЭРГЭНД ХАВЧУУЛАГДАН НАС БАРЛАА

**2017.01.09:** Энэ мэтчилэн ослууд ээлж дараалан гарсаар байсан ч УБТЗ-ынхан ганц үг ганхийлгүй байсаар 2017 оны нэгдүгээр сарын 9-ний өдрийн 13:30 цагийн орчимд УБТЗ-ын Толгойт өртөөн дахь Зам засварын машинт станц "ПДМС"-ийн сэлгээний зам дээр вагон найруулагч хоёр суудлын вагоныг холбох үеэр завсарт нь хавчуулагдан нас барсан харамсалтай хэрэг дахин гарав. Хохирогч 52 настай байсан бөгөөд УБТЗ-д олон жил ажилласан туршлагатай мэргэжилтэн байсан гэнэ. Ийнхүү аравхан хоногийн дотор таван хүний амь нас аюулгүй ажиллагааг хангаагүйн улмаас сүйдсэн байтал энэ талаар арга хэмжээ авч, хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналтаа сайжруулж, иргэдэд сэрэмжлүүлэх нь байтугай мэдээллийг нууцалсаар байв.



### ШААМАР СУМАНД АМИА АЛДСАН ИРГЭНИЙ ХЭРГИЙГ НУУЦЛАВ

**2017.01.05:** Үүний дараа буюу шинэ он эхлээд тав хоножбайхад буюу 2017 оны нэгдүгээр сарын 5-нд дараагийн осол гарлаа. Энэ бол Сэлэнгэ аймгийн Шаамар суманд гарсан осол юм. Ослын улмаас дахин нэг хүн алтан амиа алдсан. Гэвч энэ ослын талаар УБТЗ-ын удирдлагууд нууцалж, мэдээлэл огт өгөөгүй юм.

### 15 НАСТАЙ ОХИН ГАЛТ ТЭРГЭНД ШҮРГҮҮЛЖ, ХҮНД ГЭМТЭВ

**2017.01.08:** Хоёр охины амь үрэгдсэн харамсалтай хэрэг гарсны маргааш буюу 2017 оны нэгдүгээр сарын 8-нд дараагийн осол гарав. Тодруулбал, Амгалан өртөө -Улаанбаатар хот хоорондын замд энэхүү осол гарсан байна. Амгалан өртөө -Улаанбаатар хот хоорондын замын 407 км-т 15 настай охин галт тэрэгнд шүргүүлсэн аж. Галт тэрэгнд шүргүүлсэн охины биеийн байдал хүнд байсныг ч УБТЗ-ынхан мөн л нуун дарагдуулжээ.

### ХОЁР ОЮУТАН ОХИН ГАЛТ ТЭРГЭНД ДАЙРУУЛЖ АМИА АЛДЛАА

**2017.01.07:** Харин гурав дахь осол 2017 оны нэгдүгээр сарын 7-ны өдөр Толгойт өртөөний зам дээр гарсан. Энэ талаар тухайн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхдээ ойролцоогоор 17-18 насны хоёр оюутан охин галт тэрэгнд дайруулж, газар дээрээ амиа алдсан гэж байв. Амиа алдсан хоёр охин тухайн үед чихэвч зүүчихсэн явсан учраас галт тэрэгний дуут дохиог сонсолгүй төмөр замын гармаар гарч яваад дайруулсан байна хэмээн мэдээлж байв. Төмөр замын аюулгүй ажиллагааг осол гарахаас өмнө буюу урьдчилан сэргийлэх үүднээс байнга хангаж байх ёстой төмөр замынхан арав хүрэхгүй хоногийн хугацаанд гурван ч осол гарч, дөрвөн хүний амь үрэгдчихээд байхад ямар нэгэн дорвитой арга хэмжээ аваагүй төдийгүй нийт ажиллагсдадаа ч мэдэгдэлгүй нууцлаад өнгөрчээ.

Сэтгүүлчийн өнцөг

# УЛС ТӨРИЙН ТОМИЛГОО УБТЗ-Д БУГШСААР, УЛАМ Л ХАРИУЦЛАГАГҮЙ БОЛСООР БАЙГААГИЙН ТОД ИЛРЭЛ ЭНЭ БИШ ГЭЖ ҮҮ

Э.ТУУЛ

УБТЗ-ын түүхэнд ийм ойрхон хугацаанд олон хүн амиа алдсан осол гарч байгаагүйг дээр дурьдсан. Ердөө аравхан хоногийн хугацаанд зөвхөн төмөр замынхантай, гал тэрэгтэй холбоотой ослууд ар араасаа гарч, таван хүн алтан амиа алдчихаад байхад УБТЗ-ын удирдлагуудямарнэгаргахэмжээ аваагүй гэдгийг сонсохоос ч зүрх шимширмээр. Угтаа бол гарсан осол хэргийг нуухлахын оронд төмөр замын албан хаагчид хариуцлагаа өндөржүүлэх, иргэдэд сэрэмжлүүлэх нь чухал байсан байлтай. Үнэндээ Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг УБТЗ-ын даргын суудлын наймаа сонгуулийн дараагаас өндрөө авч эхэлсэн. Учир нь манай томчууд аливаа томоохон албан тушаалд улс төрийн томилгоо хийж, өөрийн хүнээ хавчуулдаг "мода"-тай болохоороо ямар нэгэн шалтгаан гаргаж, шалтаг тоочиж байгаад л хуучин дарга нарыг "өөрийнх нь хүсэлт"-ээр өргөдлийг нь өгүүлчихдэг гэмтэй.

Тиймээс ч Засгийн газар солигдсон гэх шалтгаанаар УБТЗ-ын даргын суудал ганхаж, төрийн томчууд "Транссибирийн төмөр замуудын зохицуулах зөвлөл"-ийн 25 дугаар их хуралд оролцохоор ирсэн ОХУ-ын "РЖД" нийгэмлэгийн ерөнхийлөгч О.В.Белозёровд УБТЗ-ын даргыг өөрчлөх хүсэлтээ тавьсан гэдэг. Угтаа бол олон улсын хэлэлцээрийн дагуу УБТЗ-ын даргыг гурван жилийн хугацаатай томилох ёстой боловч манай улс сүүлийн таван жил дээрх дүрмийг мөрдөөгүйгээр барахгүй томилогдсон дарга нар нь гурван жилийнхээ хугацаанд бүтэн ажиллаж байсан түүх үгүй. Тиймээс төмөр замын даргыг улс төрийн зорилгоор өөрчилдөг асуудалд угаасаа таатай хандаад байдаггүй оросууд "өөрчлөх шаардлагагүй" гэсэн хариу барьсан ч салбар яамнаас нь бүхэл бүтэн ажлын хэсэг томилогдож, УБТЗ-ын Ерөнхий хорооны Монголын талын гурван гишүүнийг чөлөөлж, өөрийн хүмүүсийг томилсон байсан. Сураг сонсох нь ээ, "УБТЗ-ын даргыг солих үүрэг" бүхий шинэ Ерөнхий хорооны гишүүд сайдын даалгавраар УБТЗ-ын даргад Д.Загджавыг санал болгосон байгаа юм. Харин Оросын талаас түүнийг мэргэжлийн бус хүн гэдэг утгаар нь "Хүлээж авах боломжгүй" гэдэг хариуг өгөхөд нь тэр дор нь өөр хүний нэр дэвшүүлье гээд, УБТЗ-ын орлогч даргаар ажиллаж байсан, салбартаа туршлагатай гэдэг үүднээс Д.Жигжиднямаагнэрдэвшүүлсэн нь батлагдсан удаатай. Үнэндээ Д.Жигжиднямаа УБТЗ-ын орлогч даргаар ажиллаж байсан, салбараа сайн мэддэг, ажлын туршлагатай гэдэг.

Гэвч салбараа сайн мэддэг дарга таван хүний алтан амь эрсдчихээд аймшигт ослууд ар араасаа гараад байхад хаана, юу хийж явсан нь олны анхаарлыг татаж байгаа юм. Төмөр замын байгууллага бол маш хариуцлагатай, хагас цэрэгжилтийн байдалтай, хувь хүнээс өндөр хариуцлага, сахилга, дэг журам шаарддаг ажил гэдгийг хэн хүнгүй мэднэ. Гэтэл ажил дээр нь асуудал гараад, хүний амьтай холбогдож байхад УБТЗ-ын ХНН-ийн дарга Д.Жигжиднямаа гадаадад амралттай явсан гэлцэнэ.

Амарч, зугаалах нь хүний эрх гэх боловч ийм хариуцлагатай алба хашиж буй хүн адаглаад алсаас ч гэсэн арга хэмжээ аваад, хариуцах эзэнтэй болгох ёстой баймаарсан. Түүгээр ч барахгүй саяхан л гэхэд Казакстаны Төмөр замын ерөнхийлөгч Канат Алписбаяев Монголд хүрэлцэн ирж, УБТЗ-ын Татах хэсэгт зочилж, УБТЗ-ын хүндэтгэлийн музейг үзэж сонирхон дурсгалын дэвтэрт сэтгэгдлээ үлдээж байхад нь эрхэм дарга Д.Жигжиднямаа нь гараа халаасандаа хийчихээд, хүндэт зочноо үл хүндэтгэсэн байдалтай зогсож байсан гэдэг. Эх оронд нь айлчилж ирсэн хүндтэй зочинд ингэж хандаж байгаа ийм л хэнэггүй хүн энэ салбарыг авч явна гэдэг эргэлзээтэй санагдаж байна. Ерөөсөө улс төрийн томилгоо УБТЗ-д бугшсаар, улам л хариуцлагагүй болсоор байгаагийн тод илрэл энэ биш гэж үү.

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

# С.НАСАНБАТ: ХЭДИЙ ТӨСӨВ САНХҮҮ БАГА Ч, БҮТЭЭН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ онд бидэнд бага зардлаар илүү их үр дүнд хүрэх амаргүй сорилт тулгарч байгаа. Төсвийн хэмнэлтийг Засгийн газар, орон нутгийн удирдлагууд өөрсдөөсөө эхлэх ёстой. ИТХ-ын дарга, Засаг дарга нар болон Засгийн газрын бүтцийн бүх гишүүд, ажилтан албан хаагчид батлагдсан төсөвтөө багтаан үр дүнтэй ажлуудыг харилцан уялдаа холбоотой хэрэгжүүлэхээс гадна, тансаглалаас татгалзаж, төсвийн үрэлгэн зардлыг халахын төлөө үлгэр жишээ ажиллах чиглэлийг УИХ, Засгийн газраас өгсөн. Манай аймгийн хувьд 2017 онд Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх замаар Төрийн албаны хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ гэсэн хоёр үндсэн зорилт дэвшүүлсэн байгаа.

**-Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг нэлээд өндөржүүлэх нь ээ. Нөгөө талаас тэднийг сургаж дадлагажуулахад хэрхэн анхаарах вэ?**

-МУЗГ-ын тэргүүн, УИХ-ын даргаас 2017 онд төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэхэд төрийн үйлчилгээг шуурхай, боломжит байдлаар хүргэх талаар чиглэл өгсөн. Тодорхой шалгууруудыг давахгүй байгаа, ёсзүйн хариуцлагын алдаа гаргаж буй төрийн албан хаагчидтай цаг тухай бүрт нь хариуцлага тооцож ажиллана. Энэ утгаараа бид 2017 онд төрийн албан хаагчдыг чадавхжуулах ажлыг эрчимжүүлнэ. Ажил авснаас хойш аймгийн ИТХ-тайгаа хамтраад олон сургалт хийсэн. Энэ ажил цаашид үргэлжилнэ. Төсвийн хариуцлагын хүрээнд гадаад дотоод томилолт, үр ашиггүй хүлээн авалт, үр дүнгүй төсөл хөтөлбөрийг цэгцэлж салбарын яамдтай хамтарч төсвийн сахилга батыг эрхэмлэж ажиллах чиглэл авсан. 2016 оны жилийн эцсийн байдлаар төсвийн орлогоо давуулан биелүүлсэн зургаан аймгийн нэг нь Дархан-Уул аймаг. Энэ жил улсын төсвөөс татаас авахгүйгээр өөрөө өөрийгөө санхүүжүүлж улмаар улсын төвлөрсөн төсөвт Дархан-Уул аймаг орлого төвлөрүүлэх үүргийг сангийн сайдын өмнө хүлээсэн. Тэгэхээр энэ жил төрийн байгууллагууд аж ахуй нэгж байгууллага, ажил олгогчдоо дэмжихэд илүү анхаарах шаардлага урган гарч байна.

**-Энэ жил бүтээн байгуулалтын ямар ажлууд хийгдэх бол хэмээн иргэд сонирхож байгаа байх. Тухайлбал Зам тээвэр, хөгжлийн сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан авто замын ажлуудыг иргэд маш таатайгаар хүлээж авч байгаа?**

-Энэ онд хийх хоёр томоохон ажлаас дурьдвал, Азийн хөгжлийн банкны 20 сая ам.долларын санхүүжилтээр Дархан хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг нэрлэхээр байна. 2014 оноос судлаж техникийн бичиг баримтыг нь бүрдүүлж, улмаар УИХ-аар соёрхон батлуулж, зөвлөх, материал боловсруулах, орон нутийн ажлын хэсгүүд хамтран ажилласны үр дүнд томоохон бүтээн байгуулалтын ажил энэ онд эхлүүлэх гэж байна. Улаанбаатар-Дарханыг холбосон 239 км авто замыг шинэчлэхээр Зам тээврийн яам, Азийн Хөгжлийн банк харилцан тохиролцлоо. Бид орон нутгийн зүгээс холбогдох судалгаагаа хийж улмаар дээрх замын багцад Шарын гол-Дарханыг холбосон 48 км хатуу хучилттай авто зам, Хонгор-Салхитыг холбосон хатуу хучилттай авто зам, мөн 2016 онд ашиглалтад оруулсан хоёр Дарханыг холбосон найман км хатуу хучилттай авто замын үлдэгдэл 5.2 км авто замыг давхар оруулж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Энэ онд техникийн бичиг баримтыг нь бүрдүүлж, тендерийн бэлтгэл ажлыг хангана. 2018 онд замын ажил эхэлнэ. Улсын төсвийн хөрөнгө оруулалт буюу тав орчим тэрбум төгрөгөөр “Монгол малын удмын сан”-гийн барилга байгууламжийн ажлыг энэ онд барьж дуусгана. Мөн ШУТИС-ийн байрны дутуу санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдэхээр болсон.

> ...Бид 2013 онд есөн тэрбум төгрөгөөр бүтээн байгуулалтын ажил хийж байсан бол энэ онд 1.9 орчим тэрбум төгрөг аймагт хуваарилагдсан боловч 1.2 орчим тэрбум төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэх тухай Сангийн Яамнаас чиглэл ирсэн. Ингээд ОНХС-ийн үлдэгдэл 671 сая төгрөгөөр бүтээн байгуулалтын зарим ажлыг хийнэ. Тухайлбал: Дархан сумын III багийн нутаг дэвсгэрт 2.7 км хайрган хучилттай замыг хатуу хучилттай зам болгоно...

**-Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдтай байгуулсан гэрээнд аймгийн “Спорт цогцолбор”-ын асуудал хэрхэн яаж тусав. 2017 онд ажил нь хийгдэх үү?**

-Орон нутгаас Улсын Их Хуралд сонгогдсон гишүүдийн анхаарлын төвд байгаа нэг асуудал бол “Спортцогцолбор”-ын барилгыг бүрэн эрхийнхээ хугацаанд гүйцээж ашиглалтад оруулах явдал. Энэ ч утгараа УИХ-аар төсөв хэлэлцэх үед энэ жил 1.5 тэрбум төгрөгийн төсөв тавигдсан.

**-2017 онд “Орон нутгийн хөгжлийн сан” ямар чадавхтай байгаа вэ?**

-ОНХС-ийн хөрөнгө энэ онд харьцангуй буурсан. Бид 2013 онд есөн тэрбум төгрөгөөр бүтээн байгуулалтын ажил хийж байсан бол энэ онд 1.9 орчим тэрбум төгрөг аймагт хуваарилагдсан боловч 1.2 орчим тэрбум төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэх тухай Сангийн Яамнаас чиглэл ирсэн. Ингээд ОНХС-ийн үлдэгдэл 671 сая төгрөгөөр бүтээн байгуулалтын зарим ажлыг хийнэ. Тухайлбал: Дархан сумын III багийн нутаг дэвсгэрт 2.7 км хайрган хучилттай замыг хатуу хучилттай зам болгоно. Дархан сумын хүн ам олноор суурьшсан гэр хорооллын доторх VII, VIII багийн нутаг дэвсгэрээр өнгөрдөг бидний ярьж заншснаар эрүүлжүүлэхийн хажуугаар гардаг замыг орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэсэгчлэн хатуу хучилттай болгох ажлыг эхлүүлнэ. Дархан сумын VI багийн нутаг дэвсгэр “Ногооны зоорь”-ны орчимд нийтийн тээврийн буудал хийнэ. Энэ бүхний үр дүнд иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээ ойртох юм. Ерөөсөө аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Тохилог хороолол” төслийн хүрээнд гэр хорооллын хөгжилд ихээхэн анхаарна. Гэр хорооллын гэрэлтүүлгийн хүрээнд Дархан сумын XV багийн нутаг дэвсгэрт 130 сая төгрөгөөр гурван хэсэг газарт гэрэлтүүлгийн ажил хийнэ. Тус сумын VI, VII багийн иргэдэд өрхийн эмнэлгийн үйлчилгээг ойртуулна. XV багийн иргэдийн удаа дараагийн хүсэлтээр тус багийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулж өрхийн эмнэлгийн асуудлыг шийдвэрлэнэ. Дархан сумын III багийн нутаг дэвсгэр дэх Стадионыг засварлана. Үүний зэрэгцээ дутуу бариад орхисон морь барианы газрыг цогцоор нь шийднэ. Үндсэндээ 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төсөлхөтөлбөрүүдийг 2017 оны зургадугаар сар гэхэд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, бүрэн батлуулахаар аймгийн Засаг даргын орлогч нараар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгсэл, нээлттэй утсаар дамжуулж ард иргэдээс санал авч байна.

**-Жишиг хороолол төсөл**


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

1. Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр
2. Тендер шалгаруулалтын нэр: Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Хорих 433 –р ангийн хэрэгцээнд хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
3. Тендер шалгаруулалтын дугаар: Хорих 433-р анги 2017/ХМ
4. Сэлэнгэ аймгийн Мандал сумын шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллагын хэрэгцээнд хүнсний материал -г нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

| Багцын дугаар | Багцын нэр | Багцад хамаарах бараанууд | Баталгааны дүн / төг/ |
|---|---|---|---|
| Багц 1 | Гурил | 1-р гурил, 2-р гурил | 29.750.000 |
| Багц 2 | Мах , манхан бүтээгдэхүүн | Ямаа, тэмээ, адууны мах, дотор мах | 42.597.000 |
| Багц 3 | Хуурай хүнс | Цайны идээ, давс, төрөл бүрийн амтлагч, сахар, тос, цагаан будаа, шар будаа, хөц будаа | 65.911.400 |
| Багц-4 | Үрийн төмс, хүнсний ногоо | Үрийн төмс, нарийн ногооны үр, хүнсний ногоо | 66.580.000 |

Тендерийн бичиг баримтыг (хvсвэл нэмэлт хувийг) бичгээр хvсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгvй нөхцөлтэйгээр иж бvрдэл бvрийг нь 50000 төгрөг, эсхvл тvvнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Төлбөрийг дансаар Сэлэнгэ, Мандал Төрийн сангийн 100130412004тоот төгрөгийн дансанд тушаана. Тендер нь тvvнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хvчинтэй байна.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн нэг - хувьтай тэнцэх хэмжээний төгрөг (эсхvл тvvнтэй тэнцэх чөлөөтэй хөрвөх валют)-ийн дvнтэй тендерийн баталгаа ирvvлнэ.

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн борлуулалтын дундаж хэмжээ 150 сая төгрөг/

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 50 сая төгрөгөөс дээш

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил 2015, 2016 /аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ/, санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдсэн байх

**Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** 100 сая төгрөг

Тендерийг 2017 оны 01-р сарын 13- ны өдрийн 12 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирvvлэх ба нээлтэд оролцох хvсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02-р сарын 24-ний өдрийн 12 цаг 15 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Монгол улсын гарал үүсэлтэй бараанд**
**давуу эрхийн зөрүү тооцохгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хорих 433-р анги**
**Утас:99164887, 99334325**

# ЦАГ ҮЕ

**үргэлжлэх үү?**

-Орон сууцны хороололууд дахь "Жишиг хороолол"-уудыг бий болгох ажлаа үргэлжлүүлнэ. Орон сууцны арван багийн нийтийн эзэмшлийн талбайд хотын өнгө үзэмжид нийцсэн хогийн савыг нэг багт дөрвөөр тооцож 40 орчим хогийн сав байрлуулна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийтийн аж ахуй, үйлчилгээний газарт парк шинэчлэл хийнэ. 2014 онд таван самосвол авч өгсөн байдаг. Хэрэгцээ шаардлагын дагуу өндөржилтийн машин, хог ачих зориулалтын таван тонны даацтай автомашин авч өгнө. Хавар бэлэн тарьц бэлдэж зорилгоор Байгаль орчныг хамгаалах сангаас өвлийн хүлэмжийг барихаар төлөвлөж байна. Ингэснээр төсөв хэмнэхийн дээр 2018 онд өөрсдийн бэлтгэсэн тарьцаараа ногоон байгууламжаа нэмэгдүүлж хотын өнгө үзэмжийг сайжруулах ажилд шинэчлэл гарна гэж тооцож байна.

**-Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг иргэд ихэд сонирхдог. 2017 онд** нь ажилдаа орчихсон 2016 оны боловсролын салбараас хэмнэгдсэн хэмнэлтийн 36 сая төгрөгний хөрөнгө оруулалтыг бид энэ цэцэрлэгт хийж энэ ондоо багтаж ашиглалтад орно. Мөн Нийгмийн Даатгалын хэлтсийн хуучин барилгыг 220 сая төгрөг буюу балансын үнээр Нийгмийн Даатгалын сангаас худалдан авч цэцэрлэгийн зориулалтаар нь засварлаж, Дархан сумын IX багийн хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалтыг сайжруулна. Цаашлаад Шарын гол сумын Шаазгайтын цэцэрлэгийг өргөтгөх асуудлыг сум орон нутгийн удирдлагатай ярьж байна. Ингэж бид 2017 онд 92.3-аас дээш хувьд хүргэчих боломжтой.

**-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хийгдэх шинэлэг ажлуудаас нэрлэвэл?**

-Энхий ээлжинд "Багш хотхон"-ыг байгаа нөхцөл боломжоондоо тулгуурлаж шийдвэрлэхийг зорьж байгаа. Бид өмнө нь XV багийн нутаг дэвсгэрт хотхоны хэмжээнд төлөвлөж байсан. Гэтэл эдгээр их, дээд сургуулиуд босоо удирдлагатай болж салж нэгдсэнтэй холбоотойгоор бидний төлөвлөсөн төсөл Дархан-Уул аймагт шилжүүлж барих хүсэлтийг орон нутгийн зүгээс УИХ, Засгийн газарт уламжилж байна. Хэрэв тус үйлдвэр манай аймагт орж ирвэл олон талын ач холбогдолтой. Энд монгол малын удмын сан нь байна. Мөн энд эсийн бүтээгдэхүүн гаргадаг "Дархан Минж", "Дархан Нэхий" гэх хоёр том үйлдвэр нь байна. Манай станцын уурны дөнгөж 20, 30-хан хувийг ашигладаг. Цаана нь 60, 70-аад хувь нь бэлэн байна. Эрчим хүчний эх үүсвэр бүрэн боломжоотой байна. Дарханы Дулааны Цахилгаан Станц суурилагдсан хүчин чадлаа 35 мВ-аар нэмэгдүүлэхэд байна. Нарны цахилгаан станц ашиглалтад орлоо. Мөн Франц улс Дархан хотод 40 мВ-ын нарны цахилгаан станц барья газрын асуудлыг шийдэж өгөөч гэсэн хүсэлт ирүүлсэн. Ажиллах боловсон хүчин байна. Арьс ширний үйлдвэр ороод ирэхээр Хараа голыг маань бохирдуулна гэсэн ойлголт иргэдийн дунд бий. Бид БНХАУ-ын Хэбэй муж, Солонгосын Кёнги аймаг, Туркийнарьсширболовсруулах үйлдвэр, технологиудыг газар дээр нь очиж үзсэн. Одоогоор Улаанбаатарт ажиллаж буй бага насны хүүхэд суух зориулалт бүхий машины сандалны төслийг БНТУ-ын Засгийн газрын ТИКА байгууллагын буцалтгүй тусламжаар шийдвэрлэхээр саналаа өгөөд байна. Япон улсын Засгийн газрын элчин сайдын яамаар дамжуулж, Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд Хонгор сумын дунд сургуулийн сурагчдын дотуур байрыг 130 сая төгрөгийн хөрөнгөөр засварлахаар болсон. Шарын гол сумын Шаазгайтын хоёрдугаар цэцэрлэг, зургадугаар сургуулийн гадна бохирын асуудлыг мөн "Өвсний үндэс" хөтөлбөрт санал болгохоор бэлтгэж байна. Дархан хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдлаар боловсруулж байгаа Арт констракшн компанийн төсөлд Койкагийн зөвлөх багийг авч ажиллуулахаар саналаа уламжилсан зэрэг гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд хийхээр олон ажлууд байна.

**-Улаанбаатар хотод утааны асуудал хурцаар тавигдаж байгаа. Энэ асуудалд манай аймаг одооноос анхаарах шаардлагатай байх.**

# БАЙГУУЛАЛТАА ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ

**концессийн гэрээгээр ямар ажлууд хийгдэх вэ?**

-Концессийн асуудлыг МУЗГ анхааралдаа авч, орон нутгийн хэмжээнд энэ асуудлыг төр хязгаарласан чиглэлтэй байна. Тиймээс концессийн асуудал 2017 онд Дархан-Уул аймагт байхгүй. Харин бид төр, хувийн хэвшлийн хүрээнд бүтээн байгуулалтын ажил дээр нягт хамтарч ажиллана. Тухайлбал, "Халнит" компанийн санхүүжилтээр зургаан давхар "Төвийн бүсийн эмнэлгээ, оношилгооны төв"-ийн барилга баригдсан, 2017 онд ашиглалтад оруулахаар хүлээж байна. "Сонголон Хайрхан" компани дөрвөн одтой зочид буудал барихаар Залуучууд театрын дэргэд суурийг нь тавьсан байна. Бизнес төлөвлөгөө нь орон нутгийн зүгээс дэмжихээр Солонгосын талд танилцуулж байна. Энэ бол аялал жуулчлал хөгжих үндсэн суурь гэсэн үг. Хувийн хэвшлийн оролцоотойгоор цэцэрлэгийн асуудлыг дэмжинэ. Хувийн хэвшлээр дамжуулж ажлын байр нэмэгдүүлнэ. Хэдэн зуун хүнтэй том үйлдвэр барина гэж ярихаасаа илүү тав, 10, 20 хүнтэй үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжинэ.

**-Цэцэрлэг гэснээс 2017 онд сургуулийн өмнөх насны хамран сургалтыг 92.3 хувьд хүргэнэ гэж салбарын сайдтай гэрээ байгууллжээ. Энэ боломжийн талаар тодруулаач?**

-Өнгөрсөн хугацаанд бид бүх боломжоо ашиглаж СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлсэн. Мөн хувийн хэвшлийн цэцэрлэгийг дэмжиж газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газар олголтуудийсэн. Хувийн хэвшлийн анхны цэцэрлэгийн зориулалт бүхий стандарт барилга 25 дугаар хороолол буюу XV багийн нутаг дэвсгэрт баригдлаа. Энэ жил VI багийн иргэн н.Баярцэнгэл цэцэрлэгийн зориулалтаар газар авч, барилгын ажлаа эхлүүлэх гэж байна. Энэ мэтчилэн бид хувийн хэвшлийн цэцэрлэгүүдээ дэмжинэ. Мөн хүүхэд харах үйлчилгээний хүрээнд ажиллаж буй цэцэрлэгүүдээ ч дэмжиж ажиллана. Тун удахгүй бидний хэлж заншсанаар Прокурорын хашаан дотор 2016 онд концессоор хийгдсэн цэцэрлэг хүүхдээ авахад бэлэн болж байна. Удирдлагууд хэрэгжих боломжгүй болсон. Гэхдээ орон нутгийн хэмжээнд "Дархан их сургууль" төслийг хэрэгжүүлэхээр судалж байна. Уг саналыг би өмнөх бүрэн эрхийнхээ хугацаанд Турк улсын элчин сайдад тавьж байсан. Ер нь боловсролын салбарыг ярихаар багшлах боловсон хүчний чадавхийн асуудал зайлшгүй сөхөгдөнө. Тиймээс бид багш нараа сургаж чадавхжуулах төслийг Шарын гол сумаас эхлүүлж байна. Гавьяат багш н.Амгаланагаар ахлуулсан ажлын хэсэг хариуцан ажиллах юм. Ирэх хичээлийн жилээс Орхон, Хонгор, алслагдсан багуудынхаа багш нарыг чадавхжуулах замаар анги дүүргэлтээ сайжруулна.

**-Манай улсад малын гоц халдварт өвчлөл гарч байна. Саяхан Дархан-Уул аймагт хонины цэцэг өвчин гарч энэ сарын 10-нд хорио цээрийн дэглэмийг бууруулсан. Энэ талаар?**

-Мэдээж энэ бол манай аймгийн хэмжээнд биш улс орны хэмжээнд экспортын олон ажлыг зогсонги байдалд оруулсан таагүй мэдээ. Саяхан Улаанбаатар хотод хийсэн зөвлөгөөний үеэр ирэх дөрвөн жилд "Монгол малыг эрүүлжүүлэх хөтөлбөр"-т Оросын Холбооны улстай хамтарч ажиллахаар болсон тухай Хүнс, Хөдөө аж ахуйн сайд П.Сэргэлэн мэдээлсэн. Энэ хүрээнд улсын хэмжээнд малын гоц халдварт өвчний голомттой бүс нутгуудыг эрүүлжүүлэх ажил цогц хэлбэрээр хэрэгжихээр болсон байна.

**-Тэгэхээр 2016-2020 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ХАА-н чиглэлээр Дархан-Уул аймагт ямар ямар ажлууд хийгдэхээр төлөвлөсөн байгаа вэ?**

-Ерөнхий сайдыг Дархан-Уул аймагт ажиллах үеэр Орхон сумын иргэд төмс хүнсний ногоог боловсруулах орчин үеийн үйлдвэрийг Орхон суманд барих хүсэлт тавьсан. Энэхүү хүсэлтийн дагуу 2016-2020 онд хэрэгжих 21/100 төслийн хүрээнд төмс хүнсний ногоог гүн боловсруулах үйлдвэрийг Дархан-Сэлэнгийн бүсийн дунд буюу Дарханд барих саналыг Ерөнхий сайд дэмжсэн. Энэ чиглэлээр орон нутаг судалгааны ажлаа эхлүүлсэн. Мөн Улаанбаатар хотоос гаргаж Эмээлтэд барихаар зэхэж байгаа арьс шир боловсруулах үйлдвэрийг үйлдвэрүүд 60, 70-аад оныхоо технологиор, химийн хүчтэй хороор арьс ширнийхээ үсийг унагааж, дундуур нь нугалаад л вагонд ачдаг. Зөвхөн гадагшаа гаргах зорилготой, байгаль орчны асуудлаа шийдээгүй байдаг. Тиймээс бид арьс шир боловсруулах үйлдвэрийг зориттойгоор орон нутагтаа татаж байгаа. Дэлхийн арьс шир боловсруулдаг хамгийн орчин үеийн технологи бүхий томоохон групп үйлдвэрүүд Дарханд орж ирэх байр суурия илэрхийлсэн. Бид гадны томоохон хөрөнгө оруулагчдад нээлттэй зарлаж, технологийн дэвшлийг нэвтрүүлсэн эсийн бүтээгдэхүүн гаргахын төлөө ажиллах болно. Үүнийг дагаад тээвэр ложестик хөгжиж, ажлын байр нэмэгдэнэ гэдэг олон талын ач холбогдолтой.

**-Гадаад харилцааны чиглэлээр ямар бодлого баримтлах вэ. Энэ жилийн хувьд төлөвлөж буй гадаад айлчлалуудын талаар мэдээлэл өгнө үү?**

-Оны эхэнд БНСУ-ын Пусан хотын даргын урилгаар 20 аймгийн Засаг дарга нарын хамтаар тус хотод айлчлаад ирлээ. Пусан хот дахь Монгол улсын консулын газраас үйлдвэрийн район болох Улсан хоттой Дархан хотыг холбох тал дээр харилцан тохиролцсон. Мөн саяхан БНХАУ-ын ӨМӨЗО-ны У-Хай хоттой хамтын ажиллагааны гэрээ, санамж бичигт гарын үсэг зураад ирсэн. Ажлын байр хумигдсан энэ үед Шарын гол сумаас хөдөө аж ахуй түүн дотроо мал аж ахуйн салбарт ажиллах ажилтан гаргах гэрээ хэлцэл хийхээр Шарын гол сумын Засаг дарга Япон улсын Хоккайдо мужийн Шинзоки хотод ажиллаад ирлээ. Дархан, Улан-Үдэ ах дүү найрамдалт хот болсны 50 жилийн түүхэн ойг 2017 оны арвадугаар сард тэмдэглэхийн зэрэгцээ тус хоттой эрүүл мэнд, боловсролын салбарт илүү их хамтын ажиллагаа өргөжүүлэх боловсон хүчнээ сургах тал дээр анхаарна. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг авто замын ослоос урьдчилан сэргийлэх,

**Агаарын бохирдлыг бууруулах чиглэлд хэрхэн анхаарах вэ?**

-Агаарын бохирдлын хэмжээ их байгаа долоон аймгийн нэгэнд Дархан орсон байдаг. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд БОАЖЯам, "Цэвэр агаар сан"-гаас тодорхой ажлыг хийсэн. Энэ өвөл бид 500 ширхэг бүрэн шаталттай утаагүй зуухыг иргэддээ тараасан байна. Хүчин чадлаасаа хамаараад гурван янзын зуух байгаа. Зөвхөн зуух тараагаад асуудлыг шийдэхгүйн нь ойлгомжтой. УБ хотын гэр хорооллын айл өрхийн шөнийн тариф тэглэх аргыг Дарханд нэвтрүүлэхийг иргэддээ ч, манай ИТХ-ын төлөөлөгчдөөс тавьж байна. УБ хотын утааны 80 хувь нь гэр хорооллоос гарч байгаа бол манай аймгийн агаарын бохирдлын хэдэн хувь нь гэр хорооллоос байгаа вэ гэдгийг судлаж гаргана. Үүний дараагаар УБ хотод хэрэгжүүлж байгаа төслийг манайд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлаж эрчим хүч цахилгаан түгээх станцад хүсэлтээ тавина. Гэхдээ манай аймгийн хувьд гэр хороолол гэхээсээ илүү галлагааны зуухууд асуудал үүсгэдэг. Тиймээс энэ байгууллагуудад технологийн шинэчлэл хийх асуудлуудыг тавьж байгаа.

**-Дарханчуудын өмнө тулгамдаж байгаа өөр ямар асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөж байна вэ?**

-"Консулын уулзвар"-аас "Монгол алтны уулзвар" хүртэлх хоёр км гаруй Дархан хотын үндсэн дулааны шугамын шинэчлэл хийж 600 шугамыг солихоор болсон. Энэ шугам нь Дархан хотын нийт дулааныг хангагдаж байгаа аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 40 орчим хувийг дулаанаар хангаж байгаа үндсэн магистрал шугам. Одоогоос сар гаруйн өмнө хагарсан. 2015 онд 2-3 удаа хагарсан байдаг. Энэ асуудлыг саяхан Эрчим Хүчний сайдыг ирэх үеэр танилцуулсаны үр дүнд энэ онд сайдын багцад хоёр тэрбум төгрөгийг суулгуулж чадсан.

## Хүчингүйд тооцов

Дэлгэ овогтой Долгорсүрэнгийн УШ59040307 регистрийн дугаартай одонгийн дэвтэр гээсэн тул хүчингүйд тооцов.

Цэнд овогтой Цээсүрэнгийн улсын бүртгэлийн ү-2205012633 дугаартай 0050297 тоот орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээ гээсэн тул хүчингүйд тооцов.

## Аймгаас мэдээлж байна

СЭЛЭНГЭ АЙМАГ

### Найман сумын 152 өрхөд тусламж үзүүлнэ

Их Британи болон Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн Гамшгийн менежментийн хөтөлбөрийн хамтарсан баг Сэлэнгэ аймгийн зудтай сумдад ажиллалаа. Гамшгийн менежментийн хөтөлбөрийн хамтарсан багийнхан Сэлэнгэ аймгийн Жавхлант, Шаамар сумдад энэ сарын 25-26-ны өдрүүдэд ажиллаж цас ихтэй, зудтай байгаа тус сумдын малчин өрхүүдээр явж зудын байдалтай газар дээр нь танилцаж үнэлгээ, шинжилгээ хийжээ. Улмаар тус аймгийн найман сумын 152 өрхөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний бэлэн мөнгөний тусламж олгох санал дүгнэлт гаргасан байна. Мөн дараагийн найман сумын 240 өрхөд адил тусламжийг олгуулахаар Олон улсын Улаан загалмайн нийгэмлэгтээ санал тавихаар болжээ. Өвөлжилт хүндэрсэн сумдад ажиллах хамтарсан багийн бүрэлдэхүүнд Их Британийн УЗН-ийн Гамшгийн менежментийн хөтөлбөрийн зохицуулагч Петер Жонес, Логистик хариуцсан менежер Том Макгрегор, Амьжиргааг дэмжих хөтөлбөрийн зохицуулагч Файнбар Швини, Хяналт үнэлгээ төлөвлөлтийн зохицуулагч Элистрэйл Панч болон аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Улаан загалмайн хорооны тэргүүн Г.Бямбаа, аймгийн УЗХ-ны дарга Б.Түвшинжаргал, МУЗН-ийн Гамшгийн бэлэн байдал, тусламжийн хөтөлбөрийн баг ажиллалаа.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

### Замын цагдаагийн бэлэн бусаар торгох төхөөрөмжийг нэмэгдүүллээ

Дархан-Уул аймгийн хэмжээнд зам тээврийн осол гэмтлийг бууруулах, зөрчлийг багасгах зорилгоор олон ажил хэрэгжүүлж байгаагийн нэг нь бэлэн бусаар торгох төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажил байсан юм. Энэ хүрээнд Орон нутгийн төсвийн 33 сая төгрөгөөр бэлэн бусаар торгох 12 ширхэг төхөөрөмжийг аймгийн удирдлагууд Замын Цагдаагийн тасагт хүлээлгэн өглөө. Зөрчил гаргасан жолоочийг торгохдоо төхөөрөмжөө ашиглах бөгөөд зөөврийн компьютерээр жолоочийн үнэмлэхийг шалгаж, мэдээллийг уншиж, бичиж, түүнчлэн гаргасан зөрчил, ногдуулсан торгууль, түүнийг төлсөн байдал, цаашилбал автомашины татвар, даатгалыг хүртэл хянаж шалгах боломж бүрдэж юм байна. Бэлэн бус торгуулийн систем нэвтэрснээр иргэн бүрт хууль тэгш үйлчлэхээс гадна жолооч зөрчил гаргаагүй гэж үзэж байвал маргах боломжтой болсноороо онцлог аж. Мөн үнэмлэхээ мартсан жолоочийг захиргааны хэрэг бүртгэх журмаар заавал автомашиныг нь журмын хашаанд хийж, үнэмлэхтэй эсэхийг нь шалгадаг байсан бол энэ систем хэрэгжсэнээр тухайн хүний талаарх бүх мэдээллийг цахим байдлаар авч болно гэдгийг албаныхан хэллээ. Зөрчил гаргасан жолооч 14 хоногийн хугацаанд аль ч банкинд торгуулиа төлж болно. Хэрэв заасан хугацаанд торгуулиа төлөөгүй бол жолоо барих эрхийг нь хасах хүртэл хариуцлага тооцох аж.

ОРХОН АЙМАГ

### Сар шинийн баяр угтсан үзэсгэлэн худалдаа гарна

Монгол түмний уламжлалт баяр Цагаан сар удахгүй болох гэж буйтай холбогдуулан Орхон аймгийн Засаг дарга захирамж гаргаж, сар шинийг угтсан үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг байгуулжээ. Тус ажлын хэсгийг ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Ц.Баяржаргал ахалж байгаа аж. Орхон аймгийн хэмжээнд сар шинийн баяр угтсан үзэсгэлэн худалдаа хоёр удаа зохион байгуулагдах юм байна. Тодруулбал, Хоёрдугаар сарын 17-19-ий өдрүүдэд "Хангарьд" паласт "Цагаан сар-2017" үзэсгэлэн худалдаа болно. Үүнийг ЗДТГ, Монголын ХАҮТ-тай хамтран зохион байгуулах бөгөөд оролцогчдын 70 хувь нь Эрдэнэт хотод үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид байх гэнэ. Энэхүү үзэсгэлэн худалдааны бүртгэл Захиргааны 3-р байрны 202 тоотод явагдаж байгаа юм байна. Мөн хоёрдугаар сарын 20-25-нд Спорт хорооны "Б" заланд "Цагаан сар-Эрдэнэтэд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаа гарах аж. Уг үзэсгэлэн худалдааг аймгийн ЗДТГ, ХХААГ, Хүнсчидийн холбоо хамтран зохион байгуулж байгаа бөгөөд зөвхөн Орхон аймгийн үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг оролцуулах юм байна. Энэ нь орон нутгийн бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, иргэдийг эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хангах зорилготой бөгөөд оролцогчдыг талбайн түрээсийн төлбөрөөс 100 хувь чөлөөлж мандат олгох юм байна. Харин мандат авахыг хүссэн үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид эхлээд бүтээгдэхүүнээ Мэргэжлийн хяналтын газрын лабораторид шинжлүүлсэн байх ёстой гэх шаардлагыг тавьж буй ажээ. "Цагаан сар-Эрдэнэтэд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааны бүртгэл өчигдрөөс эхэлсэн бөгөөд ирэх сарын 16 хүртэл Хүнсчидийн холбоо болон ХХААГ-ын байранд явагдана.

ӨМНӨГОВЬ АЙМАГ

### 1200 хүүхдийн багтаамжтай шинэ сургууль ашиглалтад орлоо

Сүүлийн жилүүдэд Өмнөговьчууд боловсролын салбарт хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн хийж буй. Тэгвэл саяхан гэхэд Монгол Улсын хэмжээнд хамгийн олон хүүхдийн багтаамжтай буюу нэг ээлжиндээ 1200 хүүхэд хичээллэх боломжтой ЕБС тус аймагт ашиглалтад оржээ. Барилгын гүйцэтгэгчээр Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын таван тэрбум 60 сая төгрөгөөр "Аж констракшн" ХХК ажиллаасан байна. Одоогийн байдлаар сургууль 995 сурагчтай, 37 багш ажилчид, 38 анги танхимд үйл ажиллагаагаа явуулж байгаа аж. Сургуулийн барилгын хувьд хоёр давхар хамгийн сүүлийн үеийн чанар стандартад нийцүүлэн барьсан бөгөөд манай аймгийн хэмжээнд хамгийн том тоодогсон спорт заалтай гэдгээрээ онцлог юм. Ёслолын арга хэмжээнд Өмнөговь аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Л.Энхболд болон аймгийн удирдлагууд оролцож сурагч хүүхдүүдийг бие даан суралцах, авьяас чадвараа нээн хөгжүүлэх боломжийг хангаж тэднийг сурган хүмүүжүүлэх их үйлсэд амжилт хүсэж анги танхимын тохижолтонд нэн хэрэгцээтэй техник хэрэгсэлийг гардуулан өглөө. Аймгийн Засаг даргын Тамгын газар Орос хэл, Англи хэлний кабинет мөн хол бөмбөгийн талбайг бүрэн тохижуулж өгөхөөр болсон байна.

NO STRESS

Оддын ЦАТ

# Дакота Жонсон: Намайг Анастасиягийн дүрээр харна гэдэгт итгэхгүй байна



Орчуулсан: Б.СУМЪЯА

Нээлтээ хийсэн цагаасаа үзэгчдийг байлдан дагуулсан "Грейн амьдралын 50 сүүдэр" кино эротик хэсгүүд, сэтгэл хөвсөлзүүлсэн мөчүүдээр дүүрэн бүтээл болсон. Тэгвэл киноны үргэлжлэл болох "Харанхуйн 50 сүүдэр" кино тун удахгүй "Тэнгис" кино театрын дэлгэцнээ хоёрдугаар сарын 10-нд нээлтээ хийх гэж байна. Тус кино энэ оны хамгийн хүлээлт үүсгэсэн бүтээлүүдийн нэгээр нэрлэгдэж байгаа юм. Тэгвэл киноны гол дүр Анастасия гэх оюутан охины дүрийг бүтээсэн загвар өмсөгч, жүжигчин Дакота Жонсоны шинэхэн уран бүтээлийнхээ талаар дэлгэсэн товч ярилцлагыг орчуулан хүргэж байна.

**-"Грейн амьдралын 50 сүүдэр" киноны эхний цувралд ноёрхол, хошигнол, секс бүхий үзэгдлүүд ихтэй. Энэ нь магадгүй Анастасия Грэйн нөлөөнд автсаныг харуулсан байж болох?**

-Киноны эхний цувралын төгсгөл хэсэгт бүсгүй өөрийн амьдралаа өөрөө л удирдан жолоодох нь хамгийн чухал гэдгийг ойлгодог. Грей түүнтэй хамт байхыг хүсч байгаа л бол тавьсан шаардлагыг нь хүлээн зөвшөөрөх ёстой. Гэхдээ мэдээж, тэдний харилцаа хувьсан өөрчлөгдөх нь гарцаагүй. Анастасия заавал буулт хийх ёсгүй ч, эцсийн дүндээ өөрийгөө түүний төлөө золиослох л болно. Дурласан учраас тэр.

**-Тэгвэл үүнийг хайр гэж ойлгох уу, эсвэл нэг нэгийгээ хүлээн зөвшөөрүүлэх гэсэн зөрчил үү?**

-Хайр. Кино болон зохиолын аль алиных нь мөн чанар энэ. "Харанхуйн 50 сүүдэр" нэг нэгийгээ хүлээн зөвшөөрүүлэх гэсэн эр, эм хоёр хүний хоорондын зөрчил биш. Бие биеэ хайрлах хамгийн тохиромжтой арга замыг хайж буй хосын түүх юм.

**-Кинонд бүтээсэн дүр тань бодит байдал дээр ч дотно харилцааг шаардаж байсан байх. Жэйми /Жэйми Дорнан/ та хоёр амьдрал дээр хэр сайн найзууд вэ?**

-Бид маш онцгой харилцаатай. Би Жэймигийн эхнэр, хүүхдүүдтэй нь их ойр байдаг шүү. Амели үнэхээр гайхалтай бүсгүй. Холливудад маш олон франчайз бий. Гэхдээ миний бодлоор жинхэнэ нөхөрлөлийг бий болгож чадсан цор ганц жүжигчин нь Жэйми байх. Бид өдөр бүр хамт ажилладаг учраас эсрэгээрээ заримдаа төвөгтэй тал ч байдаг.

**-Олон нийтийн зүгээс та хоёрын нөхөрлөлийг хүлээн зөвшөөрөөсэй гэж хүсдэг үү?**

-Заавал тэгэх шаардлагагүй. Бид нэг өдөрт 13 цаг хамт ажилладаг. Нэг нэгийгээ мэдэх хангалттай цаг хугацаа байна гэсэн үг. Магадгүй олон хүн зүгээр л кино гэдэг талаас нь хардаг байж болно. Гэхдээ нөхөрлөл гэдэг тийм амархан бий болчих зүйл биш. Бидний дүрээ бүтээх арга барил ижилхэн. Ширүүхэн үзэгдлийн дараа инээж чаддаг юм. Бид одоо гүн гүнзгий холбогдсон. Амжилт гэдэг хүнд сорилт дунд амьдарч байгаа.

**-Дакота та карьераа хэрхэн үргэлжилнэ гэж харж байна вэ. Кино урлагт тухайн жүжигчнийг бүтээсэн дүрээр нь төлөөлүүлж харах гээд байдаг сөрөг тал бий?**

-Би энэ талаар төдийлөн санаа зовдоггүй. Хэн нэгэн намайг зөвхөн Анастасиягийн дүрээр төлөөлүүлж харна гэдэгт итгэхгүй байна.

**-Та юу ч хийсэн, хаана ч явсан папарацциудын дуран дор амьдардаг. Гадаад төрхөө өөрчлөх талаар бодож байв уу?**

-Би аль болох жирийн л амьдралаар амьдрахыг хүсдэг. Гэхдээ эцэг, эх маань олны танил хүмүүс болохоор хэзээ ч олны харцнаас хол амьдарч байгаагүй. Аль нэг киноны нээлтэд очих үед олны харц миний өмссөн хувцас дээр тусдаг юм. Гэхдээ дэлгүүр хэсэх үед санаа зовохоо больчихдог юм.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -11
Шөнө -23

Нөгөөдөр
Өдөр -10
Шөнө -22

## Өдрийн зурхай

**ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 08.21-17.52

**Үс засуулбал:** Бие эрхтний хүч сайжирна



*Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэх, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой.*

ОДДЫН АМЬДРАЛ

## Ираны найруулагч ОСКАРТ ОРОЛЦОЖ ЧАДАХГҮЙ БОЛЖЭЭ

Кино урлагийн хамгийн нэр хүндтэй томоохон наадам болох Оскарт иран найруулагч оролцож чадахгүй болжээ. Асгар Фархади гэгч найруулагч ирэх сард зохион байгуулагдах Оскарын наадамд "The Salesman" киногоо "Шилдэг гадаад кино" номинацид сойж буй. Гэвч Оскарын наадам болохоос өмнө АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Иран тэргүүтэй Ойрхи Дорнод, Хойд Африкийн долоо орны иргэдийг улсын хил нэвтрүүлэхгүй байх тухай зарлигт гарын үсэг зурснаар найруулагч эр шагнал гардуулах ёслолд оролцох боломжгүй болсон гэнэ. Мөн тус киноны гол дүрд тоглосон Таранех Алидости гэх бүсгүй ч мөн Оскарт оролцохгүй болжээ.

Найруулагч Асгар Фархади өмнө нь 2012 онд "A Separation" киногоороо Оскар хүртэж байсан юм. АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трамп энэ сарын 27-нд Иран, Ирак, Ливи, Сомали, Судан, Сири, Йемен гэсэн долоон орны иргэдэд хориг тавих зарлигт гарын үсэг зурсан юм. Тэрбээр террорист халдлага үйлдэх магадлал өндөртэй гэдэг утгаар аюулгүй байдлын үндсэн дээр тус хоригийг тавьжээ.

## Ч.Цэлмүүн ШИНЭ ХАЙРТАЙ учирсан гэнэ үү



UBS телевизээс зохион байгуулсан "Universe best songs" уралдааны шилдэг ялагчдаас урлагийн салбарт тун амжилттай хөл тавьсан нэгэн бол дуучин Ч.Цэлмүүн. Урлагийн амьдралд хөл тавиад тун удаагүй байхдаа сүр дуулиантайхан хуримаа хийж, хүүхэдтэй болсон ч түүний энэ амьдрал удаан үргэлжлэлгүй цэг тавьсан. Нөхрөөсөө салаад хоёр жил гаруй ганц бие явсан дуучин бүсгүй шинэ хайр дурлалтайгаа учирсан бололтой. Учир нь шинэхэн хосуудын зураг фэйсбүүк хуудаснаа тарж, олны анхаарлыг ихэд татаж байна. Дуучин бүсгүйн энэхүү үйлдэлд зарим шүтэн бишрэгчид нь тун шүүмжлэлтэй хандаж байгаагаа цахим хуудсаараа дамжуулан илэрхийлж байгаа юм. Харин дуучин Ч.Цэлмүүн нөхрийнхөө талаар нэгэн хэвлэлд өгсөн ярилцлагадаа "Өрх толгойлсон эмэгтэй болоод хоёр жил гаруй болж байна. Хүүгээ хөхнөөс гаргаагүй байхад л нөхрөөсөө салсан. Анх удаа хувийн амьдралынхаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярьж байгаа минь энэ.

Нэгэн цагт ханилж явсан хүнээ би хэзээ ч муу хэлэхгүй. Хэн нэгэн надад тэр хүнийг муулж ярихыг ч тэвчихгүй. Тэр маань өөрийнхөө хүчээр амьдралаа босгож яваа мундаг залуу" хэмээн ярьсан байдаг. Ямартай ч дуучин бүсгүй шинэхэн хайр дурлалтай учирсан бололтой.





Нар мандаж, жаргаж бас дахин мандана. Эрээнтэй бараантай амьдралын эгэл бор өдрүүд дунд аав тэмцсээр, гэр бүл хань ижил, үр хүүхдүүдийнхээ төлөө зүтгэсээр л. Амьдрал амаргүй байсан ч тэр архинд ороогүй, хүсэл мөрөөдөл нь биелээгүй ч тэр гутарч гуниагүй, хэцүү цагт тэр гэр бүлээ орхиж яваагүй...

Xander адал явдал хайгч бүлэг хүмүүсээр өөрийн багаа бүрдүүлэх ба тэр өөрийгөө дэлхийн хамгийн өндөр төвшний Засгийн газруудын сөргөлдөөн рүү чиглүүлсэн аймшигт урхинд орсноо мэднэ.





Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Erkhes Eku**

Найтаасан чинь хажуу айлын залуу "Бурхан өршөө" гэх юм. Чихэндээ ч итгэсэнгүй. "Юу гэнэ ээ" гээд орилтол, "Буянтай айлын хүргэн болоорой" ч гэх шиг. Одооны байрнуудын хана арай л нимгэн үү, үгүй юу. Ха ха ха